



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР
БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Хамрах хүрээ: Ховд аймаг

Улаанбаатар хот
2023 он

БҮЛЭГ 1. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ		1-4
1.1	Үнэлгээ хийх болсон шалтгаан, үндэслэл	
1.2	Үнэлгээний аргачлал	
1.3	Үнэлгээ хийх хүрээ	
1.4	Үнэлгээний шалгуур үзүүлэлт	
1.5	Үнэлгээний харьцуулах хэлбэр	
1.6	Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг томъёолох	
1.7	Үнэлгээний мэдээлэл цуглуулсан талаар	
1.8	Үнэлгээний багийн бүрэлдэхүүн, хугацаа	
БҮЛЭГ 2. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ		
2.1.	Төрийн болон орон нутгийн тухай өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байдал бүрэн хангагдаж байгаа эсэх талаар:	5-10
2.2.	Тендерийг хянан үзэх, тендер шалгаруулалтын үйл ажиллагааны талаар:	10-13
2.3.	Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн мэдээлэл болон тэдгээрийн гүйцэтгэлд хийсэн үнэлгээ:	13-21
2.4.	Тендер шалгаруулалттай холбоотой маргаан, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар:	21-27
2.5.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль үр ашигтай хэрэгжиж байгаа эсэх, гарч буй хүндрэл бэрхшээлийн талаар:	27-29
БҮЛЭГ 3. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ҮР ДҮН, ЗӨВЛӨМЖ		30-31
Хавсралт		
<i>Хавсралт 1.</i>	2016-2022 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл	
<i>Хавсралт 2.</i>	2019-2022 онд Ховд аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил үйлчилгээний гүйцэтгэлийн хувь болон гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл	
<i>Хавсралт 3.</i>	Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн дэлгэрэнгүй мэдээлэл	
Хүснэгт, зургийн жагсаалт		
<i>Хүснэгт 1.</i>	Ховд аймагт 2016-2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх сургалтын тоо мэдээлэл	
<i>Хүснэгт 2.</i>	Худалдан авах ажиллагааны журмын хэрэгжилт (2022 оны байдлаар)	

- Хүснэгт 3.* Цахим системийн ашиглалтыг тендер шалгаруулалтын журмаар харуулбал
- Хүснэгт 4.* 2016-2022 онд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах журам
- Хүснэгт 5.* 2016-2022 онуудад Ховд аймагт орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах журам
- Хүснэгт 6.* Төсөл, арга хэмжээ төрлөөр (2021-2022 оны байдлаар)
- Хүснэгт 7.* Зураг төсөв хийгдээгүй эхэлсэн барилга байгууламжууд
- Хүснэгт 8.* Гэрээний хугацаанд дуусаагүй, ашиглалтад ороогүй төсөл, арга хэмжээ
- Хүснэгт 9.* 2021-2022 оны гүйцэтгэлийн аудитын тайлангаар гэрээний хугацаанд дуусаагүй төсөл арга хэмжээ
- Хүснэгт 10.* Төрийн худалдан авах ажиллагааны газраас Ховд аймгийн хүрээнд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны мэдээлэл
- Хүснэгт 11.* Нийт тендер шалгаруулалтад гаргасан гомдлын эзлэх хувь (2018-2022 он)
- Хүснэгт 12.* Ховд аймгийн тендер шалгаруулалттай холбоотой гарсан гомдол
- Хүснэгт 13.* Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо
- Хүснэгт 14.* Зураг төсөв нь хийгдээгүй 2022 онд эхлэх барилга байгууламжийн жагсаалт
- Зураг 1.* Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Шударга байдлын 2022 оны үнэлгээг оноогоор авч үзвэл:
- Зураг 2.* Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орж ажилласан мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, ИТХ-аас томилсон иргэний талаарх мэдээлэл
- Зураг 3.* Тендер шалгаруулалттай холбоотой гомдол гаргасан байдал
- Зураг 4.* Сангийн яаманд тендер шалгаруулалттай холбоотой ирүүлсэн гомдлын шийдвэрлэлт (2014-2022 оны статистик мэдээ)
- Зураг 5.* Гаргасан гомдлын тоо (2018-2022 он)
- Зураг 6.* Тендерийн маргаан хянан шийдвэрлэсэн байдал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуй, нэгж байгууллага
АТГ	Авлигатай тэмцэх газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл

НЭГ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Үнэлгээ хийх болсон шалтгаан, үндэслэл:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг анх хуульчлан зохицуулснаас хойш 20 гаруй жил өнгөрсөн ч төрийн худалдан авах ажиллагааны эрх зүйн харилцаа нь эдийн засаг болон эрх зүйн харилцаанд харьцангуй шинэ тутам хөгжиж буй салбарын нэг юм.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.4."Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно." гэсэн зорилтыг дэвшүүлж энэ хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын статусыг шийдвэрлэж, чадавх, үйл ажиллагааны цар хүрээ, чиг үүргийг тодорхой болгох асуудлыг тусгасан байна.

Монгол Улсын Их Хурлаас 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль нь төсвийн хүрээнд хийгдэх худалдан авах ажиллагааг захиалагч бие даан зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналт, хариуцлагыг бүрэн хүлээх, төлөвлөсөн бус тогтолцоонд шилжсэн байна.

Гэвч уг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш өнөөг хүртэл бусад хууль тогтоомжтой холбогдуулан их, бага хэмжээгээр тасралтгүй нэмэлт, өөрчлөлт оруулж ирсэн бөгөөд нийт 28 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтоос 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн УИХ-03/2325 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т "...хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно." гэснийг үндэслэн Улсын Их Хурлын Тамгын газраас үнэлгээг гүйцэтгэлээ.

Улсын Их Хурлын гишүүнээс ирүүлсэн үнэлгээ хийлгүүлэх тухай хүсэлтэд дурдсан асуудлын дагуу уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх дараах шалтгааныг зөвхөн Ховд аймгийн хүрээнд тодорхойлсон. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д заасан зорилтын хүрээнд уг хууль нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах харилцааг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэх;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байдал бүрэн хангагдаж байгаа эсэх;
- Тендер шалгаруулалтад оролцож байгаа этгээдүүд хуулийн хүрээнд шалгарч байгаа эсэх;

- Ховд аймагт улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн мэдээлэл болон тэдгээрийн гүйцэтгэл;
- Үнэлгээний хорооноос гаргаж буй дүгнэлтүүд нь хуульд нийцэж байгаа эсэх;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль үр ашигтай хэрэгжиж байгаа эсэх, гарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зэрэг болно.

Дээрх шалтгаан нь хуулийн үйлчлэх хүрээ, худалдан авах ажиллагааны зарчим, тендер шалгаруулах журам, тендерийг хянан үзэх үе шат, тендерийн үнэлгээ, маргаан шийдвэрлэлтийн асуудлын хүрээнд байх тул эдгээр харилцааг хуулиар бүрэн зохицуулж чадаж байгаа эсэхийг тогтоохоор хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний зорилго нь Ховд аймгийн хүрээнд хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлон, цаашид хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход хувь нэмэр оруулах явдал юм.

Үнэлгээний аргалал:

Уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийх хүрээ:

Үнэлгээний хүрээг үнэлгээ хийх зорилго, шалтгаанд тулгуурлан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн байдалд бүхэлд нь үр дагаврын үнэлгээ хийсэн бөгөөд зөвхөн Ховд аймгийн хүрээнд гүйцэтгэсэн болно.

Хуулийн хэрэгжилтэд бүхэлд үр дагаврын үнэлгээ хийхдээ хүсэлт ирүүлсэн Улсын Их Хурлын гишүүний асуултын дагуу агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэхүйц хуулийн зүйл, хэсгийг сонгож, холбогдох мэдээллийг Ховд аймгийн хувьд судлан үзэж, авч үзсэн.

Үнэлгээ хийх хүрээг тогтоож түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, дараах алхмуудын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож томъёолох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Богино хугацаанд төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл цуглуулах аргыг сонгож, цуглуулсан.

Үнэлгээний шалгуур үзүүлэлт:

Үнэлгээний хүрээ, онцлогоос шалтгаалан хуулийн хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлоход чиглэгдсэн дараах шалгуур үзүүлэлтийг аргачлал¹ын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг бодитойгоор илэрхийлж чадах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзан сонгов.

¹ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”

Үнэлгээний үндсэн шалгуур үзүүлэлтүүдээс “зорилгод хүрсэн түвшин”, “практикт нийцэж байгаа байдал”, “хүлээн зөвшөөрөгдсөн байдал” гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг үнэлгээний хамрах хүрээнд тухайн зохицуулалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой гэдгийг харгалзан үзэж сонгосон болно. Үүнд:

д/д	Шалгуур үзүүлэлт	Тодорхойлолт
1	Зорилгод хүрсэн түвшин	хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг тогтоох замаар хууль зорилгодоо хүрсэн эсэхийг тогтооно.
2	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	хууль тогтоомжийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг тогтооно.
3	Практикт нийцэж байгаа байдал	хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон бодит амьдрал дээр гарч буй эерэг болон сөрөг үр дагаврууд, хэрэгжилтийн явцад гарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлно.

Шалгуур үзүүлэлтийг сонгохдоо тухайн зүйл, хэсэг, заалтын "хэрэгжилтийг хамгийн сайнаар илэрхийлэн гаргаж ирэх" гэсэн шаардлагаар сонгосон бөгөөд тухайн хуулийн зохицуулалтад төдийлөн ач холбогдолтой бус шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

Үнэлгээний харьцуулах хэлбэр:

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практикт тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаанд үндэслэнэ. Өөрөөр хэлбэл, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас нь үнэлэх учир дутагдалтай тул өмнөх үе шатанд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрд тохирсон харьцуулах хэлбэрийг сонгон үнэлгээ хийх болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох зүйл, хэсгийг үнэлэх шалгуур үзүүлэлтээр сонгож авсан зорилгод хүрсэн ба хэрэгжсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хууль хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дагавар нь анх хуулиар тавьсан зорилгоо хангаж чадаж байгааг харьцуулах аргаар тогтооно.

д/д	Харьцуулах хэлбэр	Тодорхойлолт
1	Байх ёстой болон одоо байгаа	хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш гарсан үр дагавар /одоо байгаа нөхцөл байдал/-ыг бодитоор хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хуулиаар тогтоосон шаардлага, горм, хугацаа, давтамж хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хуулийн зорилгыг хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно.
2	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар тогтоон харьцуулна.
3	Тохиолдол судлал	хууль эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй зүйл, хэсэг өөр орчин нөхцөлд (бусад улсад өөр орон нутагт гэх мэт) хэрхэн хэрэгжиж байгааг байдлыг харьцуулна.

Дээрх харьцуулалтын хэлбэрийн хүрээнд уг хуулиар тогтоосон тендер шалгаруулалтын эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтын өнөөгийн

нөхцөл байдал, Ховд аймгийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон харилцааг хэрхэн зохицуулж байгаа эсэх болон уг хууль нь үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэхийг судалж тогтоох юм.

Шалгуур үзүүлэлтийг томьёолох:

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, хэсэг, заалт бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтээ томьёолох юм.

Шалгуур үзүүлэлтийг томьёолох хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар зохицуулсан зүйл тус бүрийг шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавих бөгөөд таамаглал дэвшүүлэх болон асуулт тавихдаа аль болох товч, тодорхой томьёолох зарчим баримтлан ажиллалаа.

Үнэлгээний мэдээлэл цуглуулсан талаар:

Үр дагаврын үнэлгээний мэдээллийг шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэрт үндэслэн баримт бичгийн болон статистик дүн шинжилгээний арга зүйг ашиглан чанарын болон тоон судалгаанд үндэслэн дүн шинжилгээ хийлээ. Энэ хүрээнд дараах мэдээллийг цуглуулсан.

1. Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээс Ховд аймгийн аж ахуйн нэгжийн тендер шалгаруулалтын мэдээлэл;
2. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А-1/1894 дугаар албан бичиг, Төрийн захиргааны төв байгууллага болох Сангийн яамны 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 03/3680 дугаар албан бичиг, Ховд аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр ирүүлсэн 1/900 дугаар албан бичиг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 03/1144 дүгээр албан бичгээр ирүүлсэн статистик мэдээ, Үндэсний аудитын газрын харьяа Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан”, “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан зэрэг албан эх сурвалж;
3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, “Шударга байдлын үнэлгээ судалгааны тайлан”, “Монгол Улс дахь авлигын эсрэг шинэтгэл”, “Монгол Улсын 4 дүгээр шатны мониторинг” зэрэг судалгааны тайлан, холбогдох бусад судалгаа, мэдээлэл;
4. Худалдан авах ажиллагааны талаарх гадаад орнуудын харьцуулсан судалгаа зэрэг болно.

Үнэлгээ хийсэн бүрэлдэхүүн хугацаа:

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн хянан удирдаж, ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Б.Энхмаа, Ц.Элбэгзаяа нар 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

ХОЁР. ХОВД АЙМГИЙН ХҮРЭЭНД ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Манай улсын хувьд худалдан авах ажиллагаа нь хэдийгээр төр, орон нутгийн өмчийн гэсэн тодотголтой боловч санхүүжилтийн өөр өөр эх үүсвэр, эдийн засгийн харилцан адилгүй орчинд хийгддэг гэж хэлж болно. Өнөөгийн байдлаар төр, орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны эх үүсвэр нь 1) улсын төсөв, 2) орон нутгийн төсөв, 3) Засгийн газрын тусгай сангууд, 4) Засгийн газар хоорондын гэрээний дагуу орж ирж байгаа гадаадын зээл, тусламж, 5) төрийн өмчийн болон түүний оролцоотой улсын үйлдвэрийн газруудын хөрөнгө зэрэг хэд хэдэн үндсэн сувгаас бүрдэж байна.

2.1.Төрийн болон орон нутгийн тухай өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байдал бүрэн хангагдаж байгаа эсэх талаар:

Ил тод байдал гэдэг нь “худалдан авах ажиллагааны нээлттэй байдлыг хэлэх бөгөөд сонирхогч бүхий л талуудад худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг үе шат бүрээр нь алагчлахгүй, хууль бус давуу байдал үүсгэхгүйгээр нээлттэй хүртээмжтэй байлгах, хууль бусдавуу байдал үүсгэхгүйгээр нээлттэй хүртээмжтэй байлгах, мэдээллийн бүх хэрэгсэл түүний дотор электрон, интернэт сувгийг энэ зорилгод ашиглахыг хэлнэ².” гэж тодорхойлсон.

Транспэрэнси Интернэшнл байгууллагаас төрийн худалдан авах зарчмуудыг тодорхойлохдоо ардчилал, шударга ёсыг тулгуур үндэс болгож, шударга ёс, ил тод байдал, хариуцлага тооцох механизм, шударга, хэмнэлт, үр ашигтай байх гэсэн зарчмуудад тулгуурлах ёстой гэж үзсэн байна³. Харин Азийн хөгжлийн банкны зээлдэгчдэд зориулсан худалдан авах ажиллагааны журмын 1.4-т «ил тод байдал» гэдгийг худалдан авах ажиллагаанд холбогдох баримт бичгийг бэлтгэх, худалдан авах ажиллагааны явцыг хянах замаар сонирхсон бүх этгээдийг худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг үнэ төлбөргүйгээр эсхүл бодит өртгөөр нь зохих шаардлагын дагуу цаг тухайд нь олон нийтэд нээлттэй мэдээллийн хэрэгслээр дамжуулан авах боломжоор хангах, худалдан авах ажиллагааны талаар тайлагнах тодорхой системтэй байх, зөвхөн хуулийн үндэслэлтэй нөхцөлд гэрээнд нууцлалтай холбоотой заалт оруулах зэргээр баталгаажуулахыг хэлнэ гэж тодорхойлсон байдаг.

Манай улсын хувьд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэж хуульчилсан байдаг.

Тус хуулиар худалдан авах ажиллагааны мэдээллийн хүртээмж, нээлттэй байдлыг хангах чиглэлээр нэлээд эерэг нөхцөлийг бүрдүүлж, тендерийн урилгыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх зарчмыг тодруулан хуульчилж, тендер шалгаруулалтын зар болон үр дүнг www.tender.gov.mn цахим хуудсанд зарладаг байхаар журамлаж, тендертэй холбогдсон маргааныг таслах, гомдол өргөдлийн хариуг өгөх арга механизмыг тодорхой тусгажээ.

² Нээлттэй нийгэм форум “Төрийн худалдан авах ажиллагаа болон авлига” судалгааны тайлан (2009 он)

³ Wiehen.M, Olaya.J (2007) The term of Procurement. In Kenneth. K (Ed) Curbing Corruption in Public Procurement. Transparency International. P.13


Хуульд тендер шалгаруулалтын мэдээллийг ил тод, нээлттэй зарлаж, сонирхсон этгээдэд саадгүй олгох, тендерийн урилга, тендер шалгаруулалтын үр дүнг нийтэд мэдээлж, цахим системд зарлах зохицуулалтыг тусгасны дагуу Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”⁴ мөн Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”⁵-аар энэхүү харилцааг зохицуулж байна.

Гэвч худалдан авах ажиллагааны ил тод байдлыг бэхжүүлэх чиглэлээр иргэд, олон нийтийн хяналтад хяналт тавих үйл ажиллагаа, тендерийн үр дүн, эцсийн үр өгөөжийг хянан дүгнэх, түүнд иргэд оролцох боломжийн талаар эрх зүйн нарийвчилсан зохицуулалтыг тусгаагүй байна.

Ховд аймгийн хүрээнд: Засаг даргын Тамгын газраас төрийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжид түргэн шуурхай хүргэх, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь ил тод, хариуцлагатай байгаа эсэхийг тогтоох үнэлгээ хийхэд цаг хугацааны хувьд богино, Ховд аймгийн иргэд, аж ахуйн нэгжээс санал асуулга авах боломж хязгаарлагдмал байсан учир бэлэн байгаа судалгааны тайланг эх сурвалж болгон авч үзлээ.

“Эс Ай Си Эй” ХХК болон “Бодлогын шийдэл” ТББ-ын Авлигатай тэмцэх газар (цаашид “АТГ” гэх)-ын захиалгаар “Шударга байдлын үнэлгээ-2022 он” судалгааны ажлыг гүйцэтгэсэн бөгөөд уг тайланд төрийн байгууллагуудаар үйлчлүүлсэн нийт 10,600 иргэд, аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулсан ба үүний 65 хувь нь иргэн, 35 хувь нь аж ахуйн нэгж байна. Тус судалгааны тайланд шударга байдлын үнэлгээг тооцоходоо АТГ-ын даргын 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/23 дугаар тушаалаар батлагдсан “Шударга байдлын үнэлгээний аргачлал”-ыг ашигласан бөгөөд төрийн үйлчилгээг авсан иргэд, ААНБ, төрийн үйлчилгээг хүргэж буй албан хаагчид, бодлогод оролцогчдын үнэлгээний 62 нэгж үзүүлэлтийн дунджаар тооцсон байна.

Зураг 1. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Шударга байдлын 2022 оны үнэлгээг оноогоор авч үзвэл:



⁴ <https://www.tender.gov.mn/mn/rules/dtl/1577206956666/3>

⁵ <https://www.tender.gov.mn/mn/rules/dtl/1563252447899/3>

Авлигын эрсдэлийн индексийн үнэлгээнээс харахад аймаг, нийслэлийн хэмжээнд байгууллагын ил тод байдал, ажилчдын хариуцлагатай байдал нь Ховд аймгийн хувьд дунджаас доогуур буюу 64.6 оноотой байгаад анхаарч ажиллах шаардлагатайг илэрхийлж байна.

Судалгааны тайланд Монгол Улс дахь авлигын үндсэн шалтгаан нөхцөлийг цалин, орлого бага, төрийн байгууллагын хүнд суртал, хувь хүний ёс суртахуун, ёс зүйгүй байдал, хуулийн хэрэгжилт сул, авлига өгсөн авсан хүнд хариуцлага тооцдоггүй байдал, албан тушаалаа урвуулан ашигладаг байдал, иргэдийн мэдлэг сул, мэдээлэл муу байдал, танил талын нөлөө, төр засаг, нийгмийн буруу тогтолцоо, ажлаа хурдан бүтээх гэсэн сэтгэл, хувийн ашиг сонирхол, нам, улс төрийн нөлөө, төрийн албан хаагчийн боловсрол, мэдлэг, ур чадвар дутмаг байдал, ил тод бус байдал, ажилд орохын тулд өгөх гэх мэт шалтгаануудыг дурджээ.

- **Цахим системээр дамжуулан худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах нь:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэгт захиалагч тендер шалгаруулалт бүрийн урилга, үр дүнг цахим системд тухай бүр зарлахаар хуульчилсан.

Монгол Улсын Засгийн газраас төрийн болон орон нутгийн төсвийг үр ашигтай захиран зарцуулах, худалдан авах ажиллагааг хурдан шуурхай, олон нийтэд хүртээмжтэй, ил тод, нээлттэй зохион байгуулах, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ийг боловсруулан 2017 оноос бүх шатны төрийн байгууллагууд худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа ашиглаж байна.

Ховд аймгийн хүрээнд: 2021 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 118, сумдын түвшинд 79 нийт 197 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Цар тахлын хорио цээрийн үед эдгээр худалдан авах ажлыг 100% зүүм аппликэйшн ашиглаж цахим системээр зохион байгуулсан байна. Сумдын хувьд 464 ажлыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан нь сумдын нийт худалдан авалтын 85.4%-ийг эзэлж байна. 2021 онд зарлагдсан бүх тендерийн үнэлгээг 14 хоногт багтаан хийсэн бөгөөд худалдан авах ажиллагааг цаг тухай бүрд хийх, үнэлгээний хороог тасралтгүй хуралдуулах зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/190 дүгээр захирамж гарган ажилласан байна.

Харин 2022 онд Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын А/03 дугаар тушаалаар “Үнэлгээний хорооны үйл ажиллагааг нээлттэй, ид тод зохион байгуулах журам”-ыг баталж, тендер нээсний дараа 1-3 өдөрт багтаан үнэлэх, үнэлгээний хорооны хурлыг нээлттэй, ил тод байдлыг хангах зорилгоор хурлын явцыг ил тодоор лайваар шууд иргэдэд хүргэх гэх мэт өөрчлөлтийг оруулан хэрэгжилтийг хангаж ажиллажээ.

Тус аймагт 2022 оны жилийн эцсийн байдлаар хөрөнгө оруулалт бүхий 197 төсөл, хөтөлбөрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд нийтэлсэн байна.

- **Худалдан авах ажиллагааны сургалтын үйл ажиллагааны талаар:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 7¹ дугаар зүйлд худалдан авах ажиллагаанд олон нийтийн оролцооны эрх зүйн харилцааг хуульчлан зохицуулсан бөгөөд ялангуяа орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй худалдан авах ажиллагаанд тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан сонгон шалгаруулалтыг явуулах, тухайн төсөл арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд орон нутгийн иргэдийг өргөнөөр оролцуулах зарчмыг баримтлахаар зохицуулсан бөгөөд уг харилцааг Сангийн сайдын 2021 оны 174 дүгээр тушаалаар

батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-аар зохицуулж байна.

Түүнчлэн мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т заасны дагуу худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилогдсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулахаар зохицуулалтыг тусгасан байдаг.

Мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.6-д заасны дагуу үнэлгээний хорооны гишүүдэд худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтыг улсын хэмжээнд Төрийн худалдан авах ажиллагааны газраас тогтмол зохион байгуулж байна. Энэ хүрээнд 2022 онд худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 сургалтын шалгалтад 9,905 суралцагч бүртгүүлж, 775 удаагийн шалгалтад 5,215 суралцагч тэнцэж нийт гэрчилгээ эзэмшигчийн тоо 12,738 болсон байна.⁶

Ховд аймгийн хүрээнд: 2016 оноос хойш тус аймагт Үнэлгээний хороонд ажиллах иргэнийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, шинээр худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 сургалтыг 11 удаа зохион байгуулж, нийт 821 иргэнийг хамруулснаас 483 иргэн нь шалгалтад тэнцэж, гэрчилгээ авсан байна.

Хүснэгт 1. Ховд аймагт 2016-2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх сургалтын тоо мэдээлэл⁷

д/д	Сургалт хийсэн огноо	Сургалт зохион байгуулсан байгууллага	Хамрагдсан иргэдийн тоо	Тэнцсэн иргэдийн тоо
1	2016.03.22	МУИС-ийн дэргэдэх “Бизнес төв” (Тогтвортой амьжиргаа III төслийн санхүүжилтээр)	92	38
2	2017.01.11	ТӨБЗГ	77	43
3	2017.05.15	“Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төв” ТББ	43	29
4	2017.11.11	МУИС-ийн дэргэдэх “Бизнес төв” (Тогтвортой амьжиргаа III төслийн санхүүжилтээр)	58	34
5	2019.03.03	“Төсвийн удирдлагын хүрээлэн” ТББ	72	44
6	2019.03.03	“Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төв” ТББ	124	61
7	2019.05.14	“Худалдан авах ажиллагааны боловсрол төв” ТББ (Тогтвортой амьжиргаа III төслийн санхүүжилтээр)	109	80
8	2019.10.30	МУИС-ийн дэргэдэх “Бизнес төв” (Тогтвортой амьжиргаа III төслийн санхүүжилтээр)	53	33
9	2020.09.14	“Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төв” ТББ	92	57
10	2022.04.25	“Сайн худалдан авалтын зөвлөх” ТББ (Тогтвортой амьжиргаа III төслийн санхүүжилтээр)	56	33
11	2022.04.25	“Сайн худалдан авалтын зөвлөх” ТББ	45	31
НИЙТ			821	483

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7¹ дугаар зүйлийн 7^{1.4}-т “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан сонгон шалгаруулалт явуулах бөгөөд тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд орон нутгийн иргэдийг

⁶ Сангийн яамны 2023.05.25-ны өдрийн 03/3680 дугаар албан бичиг


⁷ Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2023.05.15-ны өдрийн А-1/1894 дүгээр албан бичгийн хавсралт

өргөнөөр оролцуулах зарчмыг баримтална.” гэж заасны дагуу 2022 онд тус аймагт зарлагдсан тендерт оролцогчдын 85.2% нь тухайн орон нутгийн компани, 10.3% нь орон нутагт төлөөлөлтэй компани, 4.5% нь нийслэлийн компани байна.

Ховд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021.11.03-ны өдрийн “Үнэлгээний хороонд ажиллах мэргэшсэн ажилтны жагсаалтыг батлах тухай” 71 дүгээр тогтоолоор Ховд аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, бусад сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд ажиллах мэргэшсэн ажилтны эрхтэй нийт 239 иргэний жагсаалтыг баталсан байна.

Эдгээрээс худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны А-3 гэрчилгээтэй иргэдийн төлөөлөл 125, төрийн байгууллагын 80 албан хаагч, Төрийн бус байгууллагын 34 төлөөлөл байна. Мөн уг тогтоолд үнэлгээний хороо байгуулахад жендэрийн тэгш эрхийн зарчид үндэслэн нийт гишүүдийн аль нэг хүйсийн төлөөлөл 20 хувиас доошгүй байх журмыг баримтлахыг үүрэг болгосон. 2022 онд зарлагдсан тендерийн үнэлгээний хороонд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллөөс давхардсан тоогоор 512 иргэн хуулийн хүрээнд ажиллаж, ил тод байдлын индексийг бөглөсөн байна.

Зураг 2. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орж ажилласан мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, ИТХ-аас томилсон иргэний талаарх мэдээлэл



Тайлбар: Зураг 1-д дурдсан үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орж ажилласан мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас томилсон иргэний талаарх мэдээлэлд төрийн болон иргэдийн төлөөллийн тоо мэдээллийг оруулаагүй учир зөрүүтэй байгаа болно.

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг томилсон 2016-2022 оны шийдвэрт бүхэлд нь үнэлгээ хийх боломжгүй учир Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 04 дүгээр сарын 17-ны өдрүүдийн буюу **нэг сарын хугацаанд** Үнэлгээний хороо байгуулсан **нийт 23 тушаалыг**⁸ түүвэрлэн авч үзлээ.

Эдгээрээс Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах ажиллагааны 15, Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар худалдан авах ажиллагааны 4, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 4 худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулсан тушаал байна.

⁸ Ховд аймгийн Засаг даргын 2023.05.24-ний өдрийн 1/900 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүний хувьд бүгд 5 гишүүнтэй, үнэлгээний хороог Орон нутгийн өмчийн газрын дарга эсхүл ахлах мэргэжилтэн ахлагчаар ажилласан бөгөөд Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажилласан байна. Үнэлгээний хорооны гишүүдийн хувьд тухайн орон нутгийн Засаг даргын Тамгын газрын 1 мэргэжилтэн, төрийн бус байгууллагын төлөөлөл 1, иргэний төлөөлөл 1 гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Үнэлгээний хороонд ажилласан төрийн бус байгууллагын болон иргэний төлөөлөл бүхий гишүүний оролцооны давтамжийг авч үзвэл:

- Төрийн бус байгууллагын төлөөлөл Б.Дэлгэрмаа нь нийт 10 үнэлгээний хороонд;
- Төрийн бус байгууллагын төлөөлөл О.Энхтунгалаг нь нийт 5 үнэлгээний хороонд;
- Төрийн бус байгууллагын төлөөлөл Б.Батзол нь нийт 5 үнэлгээний хороонд;
- Төрийн бус байгууллагын төлөөлөл Д.Нямжаргал нь нийт 3 үнэлгээний хороонд;
- Иргэний төлөөлөл Ж.Ганболд нь нийт 5 үнэлгээний хороонд;
- Иргэний төлөөлөл П.Эрдэнэ-Очир нь нийт 4 үнэлгээний хороонд;
- Иргэний төлөөлөл Ц.Өлзийбат нь нийт 2 үнэлгээний хороонд;
- Иргэний төлөөлөл Г.Бямбадорж нь нийт 2 үнэлгээний хороонд;
- Иргэний төлөөлөл Х.Жангарзүсэм нь нийт 4 үнэлгээний хороонд хамгийн олон удаагийн давтамжтайгаар ажилласан байна.

Дээрх нэг сарын хугацаанд Үнэлгээний хороо байгуулсан 23 тушаалаас үзвэл нэг иргэнийг олон үнэлгээний хороонд ажиллуулж байгаа нь худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байх шаардлагыг хангахгүй байна гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл, тухайн орон нутгийн хувьд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн иргэн болон төрийн бус байгууллагын төлөөлөл бүрэн хамрагдаж чадахгүй байна.

2.2.Тендерийг хянан үзэх, тендер шалгаруулалтын үйл ажиллагааны талаар:

• Тендерийг хянан үзэх – шалгаруулалт

Үнэлэх хэсэг	<p>7 дугаар зүйл. Худалдан авах ажиллагааны журам 7.1.Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:</p> <p>7.1.1.нээлттэй тендер шалгаруулалтын журам; 7.1.2.тендер шалгаруулалтын онцгой журам; 7.1.3.зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам. 7.1.4.олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам.</p>
Томьёолсон шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> - Тендер шалгаруулалтын журмыг хэрэгжүүлсэн байдал? - Шударга өрсөлдөөний зарчим хангагдаж чадаж байгаа эсэх? - Тендер шалгаруулалтын шатанд гарч байгаа түгээмэл тохиолддог асуудлууд?

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д дараах 4 журмын дагуу худалдан авах ажиллагааг явуулахаар заасан. Үүнд:

1. Нээлттэй тендер шалгаруулалтын журам;
2. Тендер шалгаруулалтын онцгой журам;
3. Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам;
4. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам.

Тендер шалгаруулалтын онцгой журам, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам, олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө. Тендер

шалгаруулалтын онцгой журмыг хэрэглэхдээ хязгаарлагдмал тендер шалгаруулалт, харьцуулалт, гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэхээр хуульчилсан.

- Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргыг мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, техник, технологи, шаардсан нарийн төвөгтэй бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх чадвартай этгээдийн тоо хязгаарлагдмал үед болон нээлттэй тендер шалгаруулалт нийлүүлэх бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээнээс шалтгаалан амжилтгүй болсон тохиолдолд хэрэглэнэ.
 - Харьцуулалтын аргыг бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь босго үнээс хэтрээгүй тохиолдолд хэрэглэнэ.
 - Гэрээ шууд байгуулах аргыг нээлттэй хязгаарлагдмал тендерийн шаардлагад нийцэх санал ирээгүй, оюуны өмчийн эрхийн улмаас зөвхөн нэг этгээдтэй гэрээ байгуулах боломжтой, тодорхой нөхцөл байдлын улмаас гүйцэтгэгчийг нэн даруй сонгох үед хэрэглэнэ.
- **Монгол Улсын хэмжээнд худалдан авах ажиллагаанд баримталсан журмын талаар:**

Худалдан авах ажиллагааны цахим системийн мэдээллээс 2022 оны байдлаар худалдан авах ажиллагааны журмыг хэрэгжүүлсэн байдлыг дүгнэж үзэхэд 9,362.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 6,016 төсөл, арга хэмжээ (цаашид “ТАХ” гэх)-ний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 463.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5,704 ТАХ-ний гүйцэтгэгчийг тендер шалгаруулалтын онцгой журмаар, 223.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 871 ТАХ-г зөвлөх үйлчилгээний журмаар, 133.9 сая төгрөгийн өртөгтэй 7 ТАХ-г олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Худалдан авах ажиллагааны журмын хэрэгжилт (2022 оны байдлаар)

Журам	Зарласан тендер шалгаруулалтын тоо	Нийт дүнд эзлэх хувь	Төсөвт өртөг (тэрбум. төгрөг)	Төсөвт өртөгт эзлэх хувь
Нээлттэй тендер шалгаруулалтын журам	6,016	47.75%	9,362.6	93.16%
Тендер шалгаруулалтын онцгой журам	5,704	45.28%	463.6	4.61%
Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам	871	6.91%	223.2	2.22%
Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам	7	0.06%	0.134	0.0%
НИЙТ	12,598	100.0%	10,049.6	100.0%

Худалдан авах ажиллагааны журмын хэрэгжилтийг төсөвт өртгөөр харьцуулахад 93.1 хувь нь нээлттэй тендер шалгаруулалтын журмын дагуу, 4.6 хувь нь тендер шалгаруулалтын онцгой журмын дагуу зохион байгуулсан байна. Үүнээс үзэхэд 2022 оны худалдан авах ажиллагаа нь тендерт оролцогчдод ил тод, өрсөлдөх тэгш боломжийг олгосон байдлаар зохион байгуулагдсан байна.

Хүснэгт 3. Цахим системийн ашиглалтыг тендер шалгаруулалтын журмаар харуулбал:

Журмын нэр	Урилга нийтэлсэн байдал	Мэдэгдэл нийтэлсэн байдал	Урилга/ Мэдэгдэлийн харьцаа	Үр дүн нийтэлсэн	Урилга/ Үр дүнгийн харьцаа
Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам	2,480.0	1,210	49.0%	2,198	89.0%

Нээлттэй тендер шалгаруулалтын журам	9,453	6,087	64.0%	9,099	96.0%
Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам	9	-	0.0%	8	89.0%
Тендер шалгаруулалтын онцгой журам	12,631	6,316	50.0%	12,152	96.0%
НИЙТ	24,573	13,613	55.0%	23,457	95.0%

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын өөрийн хөрөнгөөр хийгдэж буй худалдан авалт улсын хэмжээний нийт худалдан авалтын 48 хувийг эзэлж байгаа бол улсын төсөв 37 хувь, орон нутгийн төсөв 13 хувь байна.

- **Ховд аймгийн хүрээнд худалдан авах ажиллагаанд баримталсан журмын талаар:**

Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад баримталсан нээлттэй тендер шалгаруулалт 2016 онд 3, 2017 онд 5, 2018 онд 8, 2019 онд 34, 2020 онд 41, 2021 онд 12, 2022 онд 28 болж өссөн байна.

Харьцуулалтын аргыг ашигласан тендер 2016 онд 2, 2017 онд 5, 2018 онд 12, 2019 онд 18, 2020 онд 4, 2021 онд 2 удаа тус тус зарлагдсан байна. Харин гэрээ шууд байгуулах аргыг ашигласан тендер шалгаруулалт 2016 онд 1, 2018 онд 2, 2019 онд 1, 2020 онд 2 удаа тус тус зарлагдсан байна. 2016-2022 онд зохион байгуулсан нийт тендерт эзлэх хувь нь 3.3 хувь байна.

Хүснэгт 4. 2016-2022 онд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах журам

	Тендер шалгаруулалтын журам	Он							Бүгд
		2016	2017	2018	2019	2020	2021	2022	
1	Нээлттэй тендер шалгаруулалт	3	5	8	34	41	12	28	131
2	Хязгаарлагдмал тендер шалгаруулалт	-	-	-	-	-	-	-	-
3	Харьцуулалтын арга	2	5	12	18	4	2		43
4	Гэрээ шууд байгуулах	1	-	2	1	2	-	-	6
5	Шууд худалдан авалт	-	1	1	-	-	-	-	2
6	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	6	11	23	53	47	14	28	182

Цахим системээр зарлагддаггүй шууд худалдан авалт нийт тендерийн 1.1 хувийг эзэлж байгаа бөгөөд 2017, 2018 онуудад тус бүр 1 удаа шууд худалдан авалтаар бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан байна. 2016-2022 онд улсын төсвийн хөрөнгөөр нийт **182** бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа нээлттэй тендер шалгаруулалтын журмыг баримталсан 131 буюу нийт тендерийн 71.9%, харьцуулалтын арга 43 буюу 23.6%, гэрээ шууд байгуулах 6 буюу 3.3%, шууд худалдан авалт 2 буюу 1.1% тус тус байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад баримталсан нээлттэй тендер шалгаруулалт 2016 онд 4, 2017 онд 4, 2018 онд 13, 2019 онд 12, 2020 онд 17, 2021 онд 12, 2022 онд 15 болж 2016 онтой харьцуулахад 3.7 дахин өссөн байна. Харин хязгаарлагдмал тендер шалгаруулалт 2018 онд 68.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 удаа зохион байгуулагдсан байна.

Харьцуулалтын аргыг ашигласан тендер 2016 онд 7, 2017 онд 7, 2018 онд 35, 2019 онд 19, 2020 онд 29, 2021 онд 73, 2022 онд 28 удаа тус тус зарлагдсан байна. Харин гэрээ шууд байгуулах аргыг ашигласан тендер шалгаруулалт 2017 онд 4, 2018 онд 10, 2019 онд 1, 2020 онд 4, 2021 онд 3 удаа зарлагдсан байна. 2016-2022 онд зохион байгуулсан нийт тендерт эзлэх хувь нь 6.3% байна.

Хүснэгт 5. 2016-2022 онуудад Ховд аймагт орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах журам

	Тендер шалгаруулалтын журам	Он							Бүгд
		2016	2017	2018	2019	2020	2021	2022	
1	Нээлттэй тендер шалгаруулалт	4	4	13	12	17	12	15	77
2	Хязгаарлагдмал тендер шалгаруулалт	-	-	1	-	-	-	-	1
3	Харьцуулалтын арга	7	7	35	19	29	73	28	198
4	Гэрээ шууд байгуулах	-	4	10	1	4	3	-	22
5	Шууд худалдан авалт	-	12	8	-	-	10	-	30
6	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам	-	1	7	-	3	3	3	19
НИЙТ		11	28	74	32	53	103	46	347

Цахим системээр зарладаггүй шууд худалдан авалт нийт тендерийн 8.6 хувийг эзэлж байгаа бөгөөд 2017 онд 12, 2018 онд 8, 2021 онд 10 удаа шууд худалдан авалтаар бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан байна.

2016-2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт **347** бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа нээлттэй тендер шалгаруулалтын журмыг баримталсан 77 буюу нийт тендерийн 22.2%, хязгаарлагдмал тендер шалгаруулалт 1 буюу 0.2%, харьцуулалтын арга 198 буюу 57.1%, гэрээ шууд байгуулах 22 буюу 6.3%, шууд худалдан авалт 30 буюу 8.6%, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмыг баримталсан 19 буюу 5.5% тус тус байна.

Ховд аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад баримталсан нээлттэй тендер шалгаруулалт 2016 оноос 2022 онд 7-оос 43 болж 6.1 дахин өссөн байна.

Хэдийгээр сүүлийн нээлттэй тендер шалгаруулалтын тоо жил ирэх тусам өсөж байгаа эерэг дүн гарч байгаа хэдий ч ижил цаг хугацаанд нийт тендерт эзлэх хувь хэмжээ бага, тендер шалгаруулалтын онцгой журмаар явагдсан тендер буюу харьцуулалтын аргаас тооны хувьд 6.2 хувиар бага байна.

Судлаачдын үзэж байгаагаар харьцуулалтын арга нь бага төсөвтэй худалдан авах ажиллагааны үед хэмнэлттэй ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг боловч хуурамч үнийн санал авах замаар хүссэн нийлүүлэгчдээ эрх олгох боломжтой тул авлига хээл хахуульд өртөх эрсдэл өндөртэй⁹ гэж үздэг.

Тендер шалгаруулалтын онцгой журмыг хэрэглэх аргын нэг болох харьцуулалтын аргаар зохион байгуулсан тендер шалгаруулалтын тоо өссөн нь өрсөлдөөнт, ил тод, шударга байдлыг хангах талаар илүү дорвитой арга хэмжээ авах шаардлагатай байгааг харуулж байна.

⁹ Төрийн худалдан авах ажиллагаа болон авилга. Нээлттэй нийгэм форум. 2009 он.

2.3.Ховд аймгийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн мэдээлэл болон тэдгээрийн гүйцэтгэлд хийсэн үнэлгээ:

Ховд аймагт 2016 оноос хойш улсын төсвийн хөрөнгөөр санхүүжсэн ТАХ, барилга байгууламжийг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл, тэдгээрийн гүйцэтгэлийн талаар Төрийн худалдан авах ажиллагааны газар (цаашид “ТХААГ” гэх) болон Ховд аймаг дахь Худалдан авах ажиллагааны газар (цаашид “ХААГ” гэх)-т 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр мэдээлэл хүссэн албан бичиг хүргүүлж, тэдгээрээс ирүүлсэн мэдээлэл болон Үндэсний аудитын газрын харьяа Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан”, “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан”-д тус тус үндэслэн хийлээ.

Улсын төсвийн хөрөнгөөр 2016-2022 онд санхүүжүүлсэн ТАХ-ний гүйцэтгэл, түүний үр дүнг тооцсон нэгдсэн тайлан мэдээ байхгүй, мэдээ мэдээллийг олон удаа дутуу гаргаж, иж бүрэн ирүүлээгүй, ирүүлсэн мэдээлэл зөрүүтэй, төсөвт өртгийн мөнгөн дүнг харилцан адилгүйгээр илэрхийлсэн зэргээс шалтгаалан үнэлгээний тайланг хугацаа хоцорч, улмаар үнэлгээний ажилд хүндрэл учруулж байлаа.

Ховд аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 109.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 44 ТАХ-нд 11.2 тэрбум төгрөгийн санхүүжилт, 2022 онд 221.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 53 ТАХ-нд 53.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгохоор баталсан байна.

2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 53 ТАХ-ний 14 нь өмнөх оноос шилжин хэрэгжиж, 39 ТАХ шинээр батлагдсан. Эдгээрээс 2022 онд 31 нь бүрэн дуусахаар, 22 ТАХ он дамжин хэрэгжихээр төлөвлөгджээ. Мөн 29 ТАХ эрх шилжин хэрэгжиж, 24 ТАХ эрх шилжээгүй хэрэгжсэн байна.

2022 онд эрх шилжсэн хөрөнгө оруулалтад 19,487.5 сая төгрөгийг зарцуулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт санхүүжилтийн:

- 11,993.3 сая төгрөг буюу 61.5 хувийг барилга байгууламжид;
- 385.9 сая төгрөг буюу 2.0 хувийг автозам, гүүрний ажилд;
- 1,150.8 сая төгрөг буюу 5.9 хувийг их засварын ажилд;
- 5,190.4 сая төгрөг буюу 26.6 хувийг инженерийн шугам сүлжээний ажилд;
- 767.1 сая төгрөг буюу 4.0 хувийг бусад арга хэмжээнд зарцуулахаар тус тус олгосон байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн онд хэрэгжүүлэх ТАХ-нүүдийг салбарын байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн саналын жагсаалт гарган харьяа салбарын Төсвийн ерөнхийлөн захирагч (цаашид “ТЕЗ” гэх)-дад хүргүүлэн ажилласан байна. Аймгийн ТЕЗ-аас 2021 онд санхүү, эдийн засгийн шинжилгээ, судалгаа хийгдсэн 56,808.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 ТАХ-г, 2022 онд 39,561.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 64 ТАХ-г хэрэгжүүлэх санал хүргүүлснээс 2021 онд 44 ТАХ, 2022 онд 39 ТАХ-г хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалтын жагсаалт батлагджээ.

2021 онд шинээр хэрэгжих 29,382.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ажлаас аймгийн ТЕЗ-д 12,682.2 сая төгрөгийн 7 ажлыг, 2022 онд шинээр хэрэгжих 152,820.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 38 ажлаас аймгийн ТЕЗ-д 48,872.3 сая төгрөгийн 24 ажлыг тус тус эрх шилжүүлсэн байна.

Хүснэгт 6. Төсөл, арга хэмжээ төрлөөр (2021-2022 оны байдлаар)

д/д	Шилжиж ирсэн	Шилжиж ирээгүй	Нийт дүн
-----	--------------	----------------	----------

	Төсөл, арга хэмжээний төрөл	TAX тоо	Төсөвт өртөг	TAX тоо	Төсөвт өртөг	TAX тоо	Төсөвт өртөг
2021 он							
1	Барилга байгууламж	2	11,302.2	3	15,300.0	5	26,602.0
2	Тоног төхөөрөмж	3	960.0	1	300.0	4	1,260.0
3	Их засвар	2	420.0	1	100.0	3	520.0
4	Дэд бүтэц			1	1,000.0	1	1,000.0
2022 он							
1	Барилга байгууламж	21	43,116.3	13	103,630.6	34	146,747.0
2	Тоног төхөөрөмж	3	5,756.0	1	300.0	4	6,056.0
3	Их засвар						
4	Дэд бүтэц						
Нийт дүн		31	61,554.5	20	120,630.6	51	182,185.1

Шинээр барих барилга байгууламжийн барилгын ажил эхлэх зөвшөөрлийг аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар олгохдоо Барилгын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т заасан барилгын ажлын зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдлийг хангуулж ажиллаагүй зөрчил гарч байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийг шинэчлэн баталж, уг тогтоолын 6.3-т Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, 25.3, 25.5-д заасан барилга байгууламжийн төсөлд заавал магадлал хийхээр заасан. Харин 2022 онд зураг төсөв нь магадлалаар баталгаажуулаагүй 8,850.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 TAX байна. Үүнд:

- Дотуур байрны барилга 150 ор (Ховд, Манхан сум, Төгрөг гол баг);
- Цэцэрлэгийн барилга 150 ор (Ховд, Жаргалант сум, Бичигт баг);
- Цэцэрлэгийн барилга 75 ор (Ховд, Жаргалант сум, Алаг толгой баг);
- Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл (Ховд, Мянгад сум);
- Сумын тохижилт (Ховд, Дуут сум).

Төсвийн тухай хууль батлагдсаны дараа магадлалаар баталгаажуулж байгаагаас батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх, ажлын тоо хэмжээ өөрчлөгдөх, төсөвт тусгагдаагүй нэмэлт ажлыг бий болгох эрсдэлтэй байгааг аудитын дүгнэлтэд дурдсан байна.

Мөн барилгын зураг төсвийг иж бүрэн боловсруулж, магадлалаар баталгаажуулдаг, төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг баталснаас гүйцэтгэл удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх үндсэн шалтгаан болдог байна.

2021-2022 онд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлтээр Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 7.1, 7.2-д заасан зураг төсөв нь батлагдаагүй нийт 11 TAX-г Төсвийн тухай хуулиар батлуулсан байна.

Хүснэгт 7. Зураг төсөв хийгдээгүй эхэлсэн барилга байгууламжууд

	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг (сая.төг)	Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар баталсан огноо
2021 онд эхлэх барилга байгууламжууд					
1	Инженерийн шугам сүлжээний өргөтгөл (Ховд, Зэрэг сум)	2020	2021	1,300.0	2021.04.05

2	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ (Ховд, Жаргалант сум, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг)	2021	2023	9,389.0	2021.04.23
3	Спорт заалны барилга 300 суудал (Ховд, Алтай сум)	2021	2022	6,000.0	2021.04.05
4	Спорт заалны барилга 500 суудал (Ховд, Зэрэг сум)	2020	2021	800.0	2021.12.17
2022 онд эхлэх барилга байгууламжууд					
5	Сумын тохижилт (Ховд, Дуут сум)	2022	2022	196.0	2022.04.08
6	Түүхий эдийн төвийн барилга (Ховд, Мөст сум)	2022	2022	396.90	2022.04.18
7	Дотуур байрны барилга, 150 ор (Ховд, Манхан сум, Төгрөг гол баг)	2022	2023	3,135.2	2022.08.25
8	Цэцэрлэгийн барилга, 150 ор (Ховд, Жаргалант сум, Бичигт баг)	2022	2023	2,800.5	2022.10.01
9	Цэцэрлэгийн барилга, 75 ор (Ховд, Жаргалант сум, Алагтолгой баг)	2022	2023	1,909.8	2022.10.01
10	Кино театрын барилга (Ховд, Жаргалант сум)	2022	2023	2,449.0	2022.10.01
11	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл (Ховд, Мянгад сум)	2022	2023	1,704.1	2022.05.20
Нийт				30,080.5	

Ховд аймаг дахь ХААГ-аас 2019-2024 онуудад тус аймагт улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 138 ТАХ-ний талаарх ерөнхий мэдээлэл бүхий жагсаалтыг гарган ирүүлж, тэдгээрийн гүйцэтгэл дараах хувийн хэрэгжилттэй байна. Үүнд:

- 100 хувийн гүйцэтгэлтэй буюу бүрэн хэрэгжиж дууссан 87 ТАХ;
- 90 хувийн гүйцэтгэлтэй 5 ТАХ;
- 70-85 хувийн гүйцэтгэлтэй 15 ТАХ;
- 40-60 хувийн гүйцэтгэлтэй 13 ТАХ;
- 10-30 хувийн гүйцэтгэлтэй 16 ТАХ;
- 0 хувийн гүйцэтгэлтэй 2 ТАХ байна.

Ховд аймагт 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 48 ТАХ төлөвлөгөөт хугацаандаа бүрэн хэрэгжсэн байна. 2021 онд 109,242.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40,301.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 37 ТАХ-ээс 9,837.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл, арга хэмжээ нь бүрэн хэрэгжиж, 19,791.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9,906.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 9 ТАХ-ний хэрэгжилт дутуу, 480.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 багц төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

2021 оны хэрэгжилт хангалтгүй ТАХ-ний хувьд Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоосон, хил гааль хаагдсаны улмаас бараа материалын үнэ өссөн, материал хомс болсон зэрэг шалтгаанаас ашиглалтад оруулж чадаагүй гэсэн тайлбарыг өгсөн байна.

Ховд аймгийн ХААГ-аас ирүүлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2022 онд хэрэгжсэн ТАХ-ний гүйцэтгэлийг хувиар үнэлж ирүүлсэн мэдээллээс гэрээний хугацаандаа төсөл, арга хэмжээг дуусгаж, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй дараах 19 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 8. Гэрээний хугацаанд дуусаагүй, ашиглалтад ороогүй төсөл, арга хэмжээ¹⁰

¹⁰ Ховд аймгийн Худалдан авах ажиллагааны газраас 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 1/900 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээллээс

	Сум	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа		Төсөвт өртөг (сая төг)	Гүйцэтгэгч аж ахуйн нэгж	Гүйцэтгэлийн хувь
1	Дарви	"Шинэ хөдөө" төсөл	2021	2021	280.0 ¹¹	2-р багц "Алтайн хар сувд" ХХК	0%
2	Ховд	Нүүдлийн авто замын засвар арчлалт	2021	2021	120.0 ¹²	5-р багц "Силкрөүд номадс" ХХК	70%
3	Мөнххайрхан	Өвсний үндэс-Хүнсний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хөрөнгө Сумын эмнэлгийн өргөтгөл	2021	2022	705.0	"Вивазоне" ХХК	70%
4	Ховд	Сум багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	2021	2021	200.0 ¹³	"Дунд голын рашаан" ХХК	80%
5	Ховд	Сум багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	2021	2021	19,993.8	"Хос мөнх дөл" ХХК	0%
6	Ховд	Сум багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	2021	2021	49,885.7	"Элст хан" ХХК	90%
7	Ховд	ХНХЯ-ны харьяа байгууллагуудын их засвар, хүчирхийлэлд өртсөн хүүхэд эмэгтэйчүүдийн түр хамгаалах байр	2021	2022	78.0	"Тусгал төв" ХХК	90%
8	Зэрэг	Инженерийн шугам сүлжээний өргөтгөл	2020	2021	800.0	"Тулгат багана" ХХК	90%
9	Алтай	Спорт заалны барилга, 300 суудал	2021	2022	1,300.0	"Би Эм Жи Юу" ХХК	30%
10	Буянт сум	Цэвэр усны шугам	2022	2022	200.0	"Жаргалант буд трейд" ХХК	70%
11	Үенч	Халуун усны барилга	2022	2022	200.0	"Эх нутгийн уулс" ХХК	90%
12	Булган	Цэцэрлэгийн барилгын их засвар	2020	2022	500.0	"Харганы ус" ХХК	40%
13	Жаргалант	Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баатархайрхан, Бичиг баг/	2020	2022	913.0	"Кеналхап" ХХК	80%
14	Үенч	Цагаан эргийн услалтын систем	2022	2022	1,350.0	"Эко буянт" ХХК	80%
15	Мөст	Түүхий эдийн төвийн барилга	2022	2022	400.0	"Наран тулгуур" ХХК	80%
16	Манхан	Сумын төвийн цахилгаан хангамж	2022	2022	600.0	"Кон арч" ХХК	80%
17	Манхан	Тахилт багийн 28.5 км 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам	2022	2022	760.0	"Ноён сайхан" ХХК	90%
18	Алтай	Сумын эрүүл мэндийн төвийн барилга	2020	2022	522.6	"Вивазоне" ХХК	40%
19	Жаргалант	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн явуулын амбулаторийн автомашин	2022	2022	300.0	"Мөнх цамт хаан" ХХК	10%

¹¹ 2 багцийн төсөвт өртөг, 1-р багц бүрэн хэрэгжсэн

¹² 6 багц хөтөлбөрийн төсөвт өртөг, 5 багц нь бүрэн хэрэгжсэн

¹³ 5 багц хөтөлбөрийн төсөвт өртөг, 4 багц нь бүрэн хэрэгжсэн

Эх сурвалж: Ховд аймаг дахь Худалдан авах ажиллагааны газраас 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 1/900 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээллээс

Өмнөх онуудын хөрөнгө оруулалтаар дуусаагүй барилгын жагсаалтад бүртгэгдсэн Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламжийн барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж, тоног төхөөрөмжийн шаардлага хангаагүйн улмаас ашиглалтад ороогүй байгаа бол ХНХЯ-ны харьяа байгууллагуудын их засвар, хүчирхийлэлд өртсөн хүүхэд эмэгтэйчүүдийн түр хамгаалах байр, инженерийн шугам сүлжээний өргөтгөл, сум, багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр, халуун усны барилга, Тахилт багийн 28.5 км 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам зэрэг 5 ТАХ 90 хувийн гүйцэтгэлтэй байна гэж тайлагнасан боловч ямар шалтгааны улмаас ашиглалтад ороогүй байгаа талаар тодорхой мэдээлэл ирүүлээгүй болно.

Мөн зарим ТАХ-ний төсвийг хэрэгжих хугацаатай уялдуулалгүй баталж байсан нь заасан хугацаанд ТАХ ашиглалтад орох боломжгүй байдалд хүргэж байна. Өөрөөр хэлбэл, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” гэж заасан нь дээрх нөхцөл байдалд хүргэж байсан тул 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуулиар “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах” гэж өөрчлөн найруулсан. Мөн хуульд тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын ТАХ-ний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх зохицуулалтыг шинээр нэмж тусгасан байна.

Төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад орсон барилга байгууламжийн гүйцэтгэлийг аудитын газраас газар дээр нь хяналт шалгалт хийхэд төсөвт өртөгт суугдсан зарим ажлыг дутуу гүйцэтгэсэн зөрчил, дутагдал давтагдаж байгаа талаар гүйцэтгэлийн аудитын тайланд дурдсан байна.

Мөн эрх нь шилжиж ирээгүй, үнийн өсөлт, цар тахлаас үүдэлтэй хил гаалиар бараа материалаа оруулж ирж чадахгүй байгаа зэрэг шалтгааны улмаас хугацаандаа ашиглалтад ороогүй цэвэрлэх байгууламж 1, лабораторийн барилга 1, спорт заалны 5 барилга, эмнэлгийн 1 өргөтгөлийн барилгын ажил дуусаагүй үргэлжилж байна.

Алтай сумын тохижилтын ажил:

Ажлын төсөвт өртөгт тусгагдсан зам талбайн ажлаас гүйлтийн замыг резин будгаар будаагүй 1.8 сая төгрөг, услалтын системийн усны крант 2.5 сая төгрөг, ус нөөцлөх сав 1 ширхэг 5.5 сая нийт 9.8 сая төгрөгийн ажил хийгдээгүй.

Мөст сумын тохижилтын ажил:

Улсын комисс хүлээн авсан бодит байдлаар сандал 6 ширхэг, хогийн сав 6 ширхэг хийгдээгүй, зогсоолын цемент талбай ховхорсон, замын хурд сааруулагч хийгдээгүй зэрэг зөрчил дутагдал гарч байна.

Улсын төсвийн 2021 болон 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангаар 2021 онд 15 ТАХ, 2022 онд 10 ТАХ гэрээний хугацаанд дуусаагүй, ашиглалтад ороогүй гэсэн дүгнэлт гарсан байна. Аудитын тайланд дурдагдсан гэрээний хугацаанд дуусаагүй төсөл, арга хэмжээ болон Ховд аймаг дахь ХААГ-аас ирүүлсэн зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн хугацаа, мэдээлэл зөрүүтэй байгаа шалтгааныг тодруулахад тодорхой тайлбар өгөөгүй бөгөөд тухайн төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэний дараа аудит хийгдэх нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлж байсан.

Хүснэгт 9. 2021-2022 оны гүйцэтгэлийн аудитын тайлангаар гэрээний хугацаанд дуусаагүй төсөл арга хэмжээ

	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг (сая төг)	Гүйцэтгэгч
2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААР					
1	Спорт заалны барилга (Ховд, Жаргалант сум, Бугат, Хайрхан баг)	2020	2021	1,200.0	"Элбэг гүн" ХХК
2	Спорт заалны барилга 250 суудал (Ховд, Дарви сум)	2020	2021	1,300.0	"Богоч констракшн" ХХК
3	Спорт заалны барилга 250 суудал (Ховд, Цэцэг сум)	2020	2021	1,300.0	"Цагаан бөлбөө" ХХК
4	Багийн төвийн барилга (Ховд, Буянт сум, Наранхайрхан баг)	2020	2021	250.0	"Авга ач нар" ХХК
5	Сум багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр (Ховд)	2021	2021	200.0	Затус, Си би ай аутсорс, Алтайн хар сувд, Дунд голын рашаан, Эвлэл
6	Сум багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	2021	2021	480.0	Нам гүүр, Затус, Хос мөнх дөл, Наран тулгуур, Элст хан, Хотонт нуур, Оргил жи трейд, Алтайн хар сувд, Дунд голын рашаан
7	Инженерийн шугам сүлжээний өргөтгөл (Ховд, Зэрэг сум)	2021	2021	800.0	"Тулгат багана" ХХК
8	Сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ цэвэр, бохир ус болон дулааны эх үүсвэр (Ховд, Булган сум)	2020	2021	7,829.9	"Жаргалант луу" ХХК
9	Цэцэрлэгийн барилгын их засвар (Ховд, Булган сум)	2020	2021	500.0	"Харганы ус" ХХК
10	Сумын төвийн хатуу хучилттай автозам (Ховд, Жаргалант сум, Баатархайрхан, Бичиг баг)	2020	2021	913.0	"Кеналхап" ХХК
11	Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн автозамын барилга 60 км	2016	2021	18,173.6	-
12	Чоно харайхын гүүр (Ховд, Дөргөн сум)	2020	2021	1,500.0	"Хотгор зам" ХХК
13	Шинэ хөдөө төсөл (Ховд)	2021	2021	280.0	"Уран минж хийц" ХХК
14	Бадамлах дөл дулааны станцын өргөтгөл (Жаргалант сум, Наран баг)	2021	2021	1,000.0	-
15	Сумын эрүүл мэндийн төвийн барилга (Ховд, Алтай сум)	2020	2021	694.1	"Вивазоне" ХХК
2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГААР					
16	Малын гаралтай түүхий эд цэвэрлэх байгууламж (Ховд, Жаргалант сум)	2018	2020	5,000.0	"Саруул цамхаг" ХХК
17	Спорт заалны барилга 300 суудал (Ховд, Алтай сум)	2021	2022	1,300.0	"Би Эм Жи Юу" ХХК
18	Спорт заалны барилга 500 суудал (Ховд, Зэрэг сум)	2021	2022	1,500.0	"Баруун жонон" ХХК
19	Спорт заалны барилга (Ховд, Жаргалант сум, Бугат, Хайрхан баг)	2020	2021	1,200.0	"Элбэг гүн" ХХК
20	Спорт заалны барилга 250 суудал (Ховд, Дарви сум)	2020	2021	1,300.0	"Богоч констракшн" ХХК
21	Спорт заалны барилга 250 суудал (Ховд, Цэцэг сум)	2020	2021	1,300.0	"Цагаан бөлбөө" ХХК
22	Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторын барилга (Жаргалант сум)	2021	2022	1,913.2	"Саруул цамхаг" ХХК
23	Сумын эрүүл мэндийн төвийн барилга (Ховд, Алтай сум)	2020	2021	522.6	"Вивазоне" ХХК
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ		50,262.3			

Дээрх жагсаалтад орсон Алтай сумын спорт заалны барилга үнийн өсөлтийн зөрүүгээс төсөвт өртөг нь нэмэгдэх барилга байгууламжийн жагсаалтад орж төсөвт өртгөө нэмэгдүүлж чадаагүйн улмаас барилгын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй гэсэн байдалтайгаар 2023 оны 04 дүгээр сард ажил нь эхлээгүй байна. Харин их засварын ажлууд харьцангуй батлагдсан зураг, төслийн дагуу хугацаандаа хэрэгжин ашиглалтад орж байна.

Аймгийн хэмжээнд 2021, 2022 оны байдлаар он дамжсан, эрх шилжсэн болон эрх шилжээгүй ТАХ-нд аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар нь Барилгын хөгжлийн төвтэй гэрээ байгуулсны дагуу хамтран захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, илэрсэн зөрчлийг барилга байгууламжийн хяналтын дэвтэрт тусгаж зөрчлийн арилгуулдаг хэдий ч явцын хяналтаар илэрсэн зөрчилд өгсөн үүрэг даалгаврын биелэлт үр нөлөө багатай, зарим арга хэмжээний хувьд хяналтын ажлын үр дүн гарахгүй байгааг аудитын тайланд дурджээ.

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-ний төсөвт өртгөөс захиалагчийн хяналтын зардалд 171.9 сая төгрөгийг, 2022 онд 376.4 сая төгрөгийг суутган төвлөрүүлсэн байна. Аудитын газраас хяналтын зардлын зарцуулалтыг хянаж үзэхэд хяналтын зардлыг цаг хугацаанд нь олгоогүй, зардлыг зориулалтын бус зүйлд зарцуулсан, өмнөх оны аудитаар захиалагчийн болон зохиогчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс барилга угсралт болон их засварын ажлын төсөвт өртөг, ажлын тоо хэмжээнд заагдсан зарим ажлууд хийгдэхгүй байна. Энэ нь хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын хяналт чанартай, үр дүнтэй хийгдээгүйгээс ажлын чанар ашиглалтын шаардлага хангадаггүй, ашиглагч байгууллагуудын гомдол, иргэд олон нийтийн шүүмжлэл тасрахгүй байх гол шалтгаан болж байна.

Гүйцэтгэгч аж ахуйн нэгж нь мэргэжлийн хүний нөөц дутмаг, орон нутгаас мэргэжлийн бус хүн ажиллуулдаг, инженер техникийн ажилтан байхгүй, 1 компани зэрэг олон тендер авдаг, дуусаагүй ажил ихтэй тул ажил удааширдаг, техник тоног төхөөрөмж хангалтгүй, ажлаа хугацаа хоцорч эхэлдэг зэргээс ажил гүйцэтгэх гэрээ хугацаандаа хэрэгжихгүй байна.

Мөн ТАХ-г гүйцэтгэгч нь барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийг аймгийн Засаг даргад ирүүлснийг үндэслэн төсөл, арга хэмжээг хүлээн авах ажлын хэсэг, улсын комиссын бүрэлдэхүүнийг томилж байна. Комисс нь холбогдох хууль, дүрмийн дагуу зохиогчийн болон техникийн хяналтын нэгдсэн дүгнэлтүүд гараагүй байхад ТАХ-г г хүлээн авах, үүрэг даалгаврын биелэлтээр өгөгдсөн ажлууд хэрэгжээгүй байхад эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр санхүүжилтийг бүрэн олгох зэрэг зөрчил аудитын дүгнэлтээр гарсан байна.

- **Төрийн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн мэдээллийн хүрээнд**

ТХААГ-аас ирүүлсэн мэдээллээр 2016-2022 онд Ховд аймагт улсын төсвийн хөрөнгөөр 45,552.40 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 28 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулах журмыг баримтлан зохион байгуулсан байна.

Хүснэгт 10. Төрийн худалдан авах ажиллагааны газраас Ховд аймгийн хүрээнд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны мэдээлэл

Он	Ажил үйлчилгээний тоо	Төсөвт өртөг (сая төгрөг)	Гэрээний дүн (сая төгрөг)	Тендерийн хэмнэлт (сая төгрөг)	Тендерт оролцогчдын тоо
2016 он	1	300.0	мэдээлэл байхгүй		
2017 он	-	-	-	-	-
2018 он	6	13,599.70	11,999.69	1,600.01	-
2019 он	6	7,900.00	7,076.88	823.12	35
2020 он	6	4,884.10	4,117.05	567.05	23
2021 он	2	1,300.00	287.66	12.34	2

2022 он	7	18,568.60	17,399.69	1,168.91	17
Нийт	28	45,552.40	40,880.97	4,171.43	77

Эх сурвалж:Төрийн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн мэдээллээс

2016 онд 300 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1, 2018 онд 13,599.70 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6, 2019 онд 7,900.00 төсөвт өртгөөр 6, 2020 онд 4,884.10 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6, 2021 онд 1,300.00 сая төгрөгийн төсөвт өртгөөр 2, 2022 онд 18,568.60 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөж, эдгээр улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 28 төсөл, арга хэмжээний хүрээнд 77 аж ахуйн нэгж тендерт оролцсон байна.

2016-2022 онд ХААГ-аас зохион байгуулсан 28 тендерээс Ховд аймгийн Булган сумын багуудыг сумын төвд холбох цахилгаан дамжуулах агаарын шугам болон Жаргалан сумын Наран багийн “Бадамлах дөл” дулааны станцын өргөтгөл хийх гэсэн 2 тендер амжилтгүй болсон байна. Булган сумын багуудыг сумын төвд холбох цахилгаан дамжуулах агаарын шугам хийх ажлын хүрээнд 2 удаа, “Бадамлах дөл” дулааны станцын өргөтгөл хийх ажлын хүрээнд 5 удаа тендер шалгаруулалтыг зарласан боловч нэг ч оролцогч санал ирүүлээгүй байна.

2022 онд Ховд аймгийн Мөнххайрхан суманд 160 суудал бүхий сургуулийн барилга барих 4,900.00 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерийг нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулж, “Вивазоне” ХХК-тай гэрээ байгуулсан боловч гэрээ цуцалсантай холбоотой Боловсролын ерөнхий газраас шүүхэд маргаан үүссэн талаарх мэдээллийг ТХААГ-аас ирүүлсэн байна.

ТХААГ-аас ирүүлсэн улсын төсвийн хөрөнгөөр 2016-2022 онд хэрэгжүүлсэн 28 төсөл, арга хэмжээг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдийн давтамжийг гарган харахад “ГЦЦЭ” ХХК, “Вивазоне” ХХК, “Хатантүнгэл” ХХК, “Буянтын боргио” ХХК, “Толын ойл” ХХК-ууд тус бүр 2 удаа тендерт шалгарч гэрээ байгуулсан байна.

Түүнчлэн тус газраас улсын төсвийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл болон тэдгээрийн гүйцэтгэлийн талаарх мэдээлэл авахыг хүссэн боловч төсөл арга хэмжээний захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ болон гэрээний үүргийн биелэлтэд тус газраас хяналт тавьдаггүй тул мэдээллийг захиалагчаас авах боломжтой гэсэн хариуг ирүүлсэн. Мөн яамдаас эрх шилжүүлэн зохион байгуулсан тендерийн мэдээлэл гарах боломжгүй тул тухайн яамдаас гаргуулан авах боломжтой талаар зөвлөсөн.

Иймээс Ховд аймгийн ХААГ-аас 2016-2022 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг гаргуулан авч ажиллалаа.

Улсын төсөв болон орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, зээл тусламж, сангуудын хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил үйлчилгээний гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн дэлгэрэнгүйг Хавсралт 1-ээс үзнэ үү.

2.4.Тендер шалгаруулалттай холбоотой маргаан, гомдол түүний шийдвэрлэлтийн талаар:

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд тендерт оролцогчдоос тендер шалгаруулалттай холбоотой гомдол гаргах, маргааныг шүүхийн өмнөх болон шүүхийн шатанд хянан шийдвэрлэх ажиллагааг тус хуулийн 54-56 дугаар зүйлээр зохицуулсан байна. Шүүхийн өмнөх шатанд тендер шалгаруулалттай холбоотой маргааныг захиалагч, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, шүүхийн шатанд захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэж байна.

Хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт “Тендер шалгаруулалттай холбогдуулан хүлээсэн үүргээ захиалагч зөрчсөн гэж үзвэл тендерт оролцогч энэ тухай мэдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор захиалагчид бичгээр гомдол гаргаж болох бөгөөд гомдолд зөрчлийг нотлох баримтыг хавсаргана.” гэж зааж уг гомдлыг хүлээж авснаас хойш ажлын 10 хоногийн дотор захиалагч хянан шийдвэрлэхээр мөн зүйлийн 54.4 дэх хэсэгт заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичигт өрсөлдөөн хязгаарласантай холбоотой гомдлыг тендерт оролцогч Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт тендерийн нээлт хийхээс ажлын 10-аас доошгүй хоногийн өмнө гаргахаар хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасан байна.

Харин захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг зөвхөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 5 хоногийн дотор гаргахаар хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасан.


Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногт багтаан хянан шийдвэрлэх бөгөөд хуулийн 55 дугаар зүйлд үндэслэн захиалагчийн шийдвэр, үйл ажиллагаатай холбогдуулан тендерт оролцогчоос гаргасан гомдлыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэх ба гаргасан шийдвэрийг захиалагч Захиргааны ерөнхий хуулийн 98 дугаар зүйлийн 98.2 дахь хэсэгт заасны дагуу заавал биелүүлэхээр Сангийн сайдын 2019 оны “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-ын 1.3-т заасан байна.

Хэрэв Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлээгүй, эсхүл гарсан шийдвэрийг эс зөвшөөрвөл тендерт оролцогч шүүхэд гомдол гаргана гэж хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт заасан.

- **Гэрээ байгуулах эрх олгосон асуудлаар гарсан гомдлын шийдвэрлэгдсэн байдал:**

Улсын хэмжээнд 2022 онд тендер шалгаруулалттай холбоотойгоор нийт 1,548 гомдлыг холбогдох байгууллагуудад гаргасан байна. Нийт гомдлын 184 нь тендерийн нээлт хийхээс өмнөх шатанд, 1,299 нь захиалагчийн шийдвэрт, 65 нь гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа эсвэл Сангийн яамны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр шүүхэд тус тус гомдол гаргасан байна.

Зураг 3. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол гаргасан байдал




Энэ нь нийт гомдлын 80 хувь нь захиалагчийн шийдвэрт гомдол гаргасан байгаа бол 15 хувь нь нээлт хийхээс өмнөх шатанд, 5 хувь нь шүүхэд хандан гаргасан байна. Шүүхэд хандсан гомдлын тоо өмнөх онтой харьцуулбал 7 хувиар буурсан байна.

Сангийн яаманд тендерт оролцогч тендерийн баталгаагаа барьцаалан үндэслэл бүхий гомдол гаргах эрх зүйн зохицуулалтын дагуу 2022 онд 40 үндэслэлгүй гомдолд барьцаалсан 303,512,309.08 төгрөг бүхий тендерийн баталгааг улсын орлого болгох шийдвэр гаргаж, Төрийн сангийн 100900000753 тоот “Тендерийн баталгааны орлого” дансанд төвлөрүүлсэн байна.

Мөн гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 5 хоногийн дотор тендерт оролцогч нараас ирүүлсэн гомдлыг хүлээн авч 14 хоногт хянан хариу өгч байна.

Сангийн яам тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх 740 шийдвэр, үүнээс тендер шалгаруулалтыг хүчингүй болгох 55 шийдвэрийг захиалагч байгууллагад хүргүүлж, захиалагч буруу шийдвэр гаргасан байсныг тендерт оролцогчдын хяналтаар дамжуулан зохих шатанд нь залруулжээ.

Зураг 4. Сангийн яаманд тендер шалгаруулалттай холбоотой ирүүлсэн гомдлын шийдвэрлэлт (2014-2022 оны статистик мэдээ)



Улсын хэмжээнд 2022 онд тендерт оролцогчдоос захиалагчийн шийдвэртэй санал нийлэхгүй гэсэн үндэслэлээр Сангийн яаманд нийт 1,299 гомдол бүртгэгдсэн бөгөөд гомдлын тоо 2018-2021 оны хооронд буурсан үзүүлэлттэй байсан боловч 2022 онд 2021 онтой харьцуулахад 429 гомдлоор буюу 49.3 хувиар өссөн байна.

Жилд бүртгэгдэж байгаа гомдлын тоог нийт тендер шалгаруулалтын дүнтэй харьцуулахад бага хувийг эзэлж байгаа хэдий ч тендерт оролцогчоос захиалагчийн шийдвэртэй холбогдуулан гаргасан нийт гомдлын 53.8-63.2 хувь нь үндэслэлтэй гомдол гарч байна. Тухайлбал, 2022 онд нийт 1,299 гомдол ирсний 61.2 хувь буюу 795 гомдол үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн байна.

	2018 он	2019* он	2020 он	2021 он	2022 он
Нийт тендер шалгаруулалт	5,694	13,837	22,598	22,334	25,349
Гомдол	1,187	1,060	1,009	870	1,299
хувь	20.8%	7.7%	4.5%	3.9%	5.1%
Үндэслэлтэй гомдол	639 53.8%	572 54.0%	590 58.5%	550 63.2%	795 61.2%
Үүнээс: Улсын төсвийн хөрөнгө оруулалт					
Гомдол	-	151	55	44	99


хувь	-	14.2%	5.4%	8.0%	7.6%
------	---	-------	------	------	------

Хүснэгт 11. Нийт тендер шалгаруулалтад гаргасан гомдлын эзлэх хувь (2018-2022 он)

Сангийн яаманд ирсэн гомдлын дийлэнх буюу 60 гаруй хувь нь захиалагч хууль зөрчсөн шийдвэр гаргасан гэсэн хариу гарч байгаа нь үнэлгээний хороо тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ хууль, журам зөрчсөн, үндэслэлгүй шийдвэр гаргах, түүнд захиалагчийн зүгээс хяналт тавихгүй байна гэж дүгнэж, цаашид захиалагч хуулийн 46 дугаар зүйлд заасан үүргийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

Ховд аймгийн хүрээнд: Сангийн яаманд 2018-2022 онуудад Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр Ховд аймагт зохион байгуулсан тендер шалгаруулалттай холбоотой нийт 94 гомдлыг гаргасан байна. Эдгээрээс 2018 онд 17 гомдол, 2019 онд 12 гомдол, 2020 онд 14 гомдол, 2021 онд 24 гомдол бүртгэгдэж байсан бол 2022 онд 27 гомдол болж өссөн байна.

Зураг 5. Гаргасан гомдлын тоо (2018-2022 он)



Гомдлыг шийдвэрлэгдсэн байдлаар нь ангилж үзвэл:

- Үнэлгээг дахин хийхээр шийдвэрлэсэн - 48,
- Гомдлыг хүлээн авах боломжгүй, шүүхэд хандах - 7,
- Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй - 12,
- Тендер шалгаруулалтыг хүчингүй болгох - 7,
- Гомдлын бүрдүүлбэр дутуу, хүлээн авах боломжгүй - 6,
- Гомдлоо эргүүлэн татсан - 3,
- Захиргааны байгууллагад гомдлоо гаргах - 2,
- Ажлын 5 хоног хэтэрсэн тул гомдол хүлээн авах боломжгүй - 2,
- Шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар дахин гаргасан гомдлыг хүлээн авах боломжгүй - 2,
- Гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн - 1,
- бусад 4 зэрэг болно.

Захиалагчийн шийдвэрт гаргасан 94 гомдлоос тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх 48 шийдвэр, тендер шалгаруулалтыг хүчингүй болгох 7 шийдвэрийг захиалагч байгууллагад хүргүүлж, захиалагч буруу шийдвэр гаргасныг залруулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.9-д заасныг тендер оролцогчдын гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгосон 1 шийдвэр, хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэгт “Шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар тендер оролцогч дахин гомдол гаргасан тохиолдолд хүлээн авахаас татгалзана.” гэж заасны дагуу буцаасан 2, гомдлыг хуульд заасан хугацаанд гаргаагүй, гомдлын харьяалал буруу, гомдлын бүрдүүлбэр хангаагүй, гомдлоо эргүүлэн татсан, бусад гэсэн 15 гомдлыг тус тус хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэж, хариуг өгсөн байна.

2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх шинээр хэрэгжсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой 2 гомдол Сангийн яаманд, захиалагчид 1, нийт 3 гомдол ирснийг хянаж, 1 гомдолд захиалагчийн шийдвэр үндэслэлтэй, 2 гомдолд үнэлгээг дахин хийлгэх шийдвэр гаргаж ирүүлсэн талаар аудитын тайланд дурдсан байна.

Хүснэгт 12. Ховд аймгийн тендер шалгаруулалттай холбоотой гарсан гомдол

	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Нийт тендер шалгаруулалт					
Гомдлын тоо	17	12	14	24	27
Үнэлгээг дахин хийх	6	3	9	15	15
Тендер шалгаруулалтыг хүчингүй болгох	1	3	-	-	3
Үндэслэлтэй гомдлын тоо	7	6	9	15	18
Хувь	41.2%	50.0%	64.3%	62.5%	66.7%


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой маргааныг анхан шатны шүүх 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ гэж Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан тусгай журмаар хянан шийдвэрлэх маргааны төрөлд оруулсан байна.

Улсын дээд шүүхийн судалгааны төвөөс болон Шүүхийн ерөнхий зөвлөл (цаашид “ШЕЗ” гэх)-ийн Шүүхийн судалгаа мэдээллийн төвөөс гаргасан Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүнгийн тухай танилцуулга, тайланд 2005-2020 онд Захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн захиргааны хэрэг маргаанаас тендертэй холбоотой маргааны тоон үзүүлэлтийг гаргахад нийт хэрэг маргааны дунджаар 3.9 хувийг эзэлж байна¹⁴.

Дээрх судалгаа нь захиргааны хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээс хэрэг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн тоонд үндэслэсэн байх тул нийт зохион байгуулсан тендер шалгаруулалтын хэдэн хувьд шүүхийн шатанд нэхэмжлэл гаргаж байгааг тодорхойлох боломжгүй байгаа талаар үнэлгээний тайланд дүгнэсэн байна.

Сангийн яам 2022 онд 1,299 гомдлыг хянан шийдвэрлэсэн бол Захиргааны хэргийн шүүхээс 2022 онд хянан шийдвэрлэсэн нийт 2,096 хэрэг маргааны 108 (7.1%) маргаан нь тендерийн маргаан эзэлж байна.

Зураг 6. Тендерийн маргаан хянан шийдвэрлэсэн байдал



ШЕЗ-өөс ирүүлсэн мэдээллээр 2017-2022 онд Ховд аймагт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн хүрээнд тендер

¹⁴Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, 2021 он, 58 дахь тал.

зохион байгуулалттай холбоотой 9 нэхэмжлэлийг шүүхэд гаргасан байна. 2017-2022 онд шинээр 11 нэхэмжлэл ирснээс 2021 онд 4, 2022 онд 1 нэхэмжлэлийг буцааж, 1 нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна.

Ховд аймагт 2019 онд тендер шалгаруулалттай холбоотой 1, 2020 онд 3, 2021 онд 6, 2022 онд 3 хэрэг буюу нийт 13 хэрэг үүсгэж, 2022 онд 2 хэргийг шилжүүлсэн гэсэн мэдээг ШЕЗ-өөс ирүүлсэн байна.

Хүснэгт 13. Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо

Он	Үзүүлэлт	Шийдвэрлэгдсэн хэргийн тоо
2017 он	Шийдвэрлэсэн хэрэг	2
	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг	1
	ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлээр шийдвэрлэсэн хэрэг	1
	Хэргийг хэрэгсэхгүй болгосон	-
2018 он	Шийдвэрлэсэн хэрэг	0
	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг	-
	ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлээр шийдвэрлэсэн хэрэг	-
	Хэргийг хэрэгсэхгүй болгосон	-
2019 он	Шийдвэрлэсэн хэрэг	1
	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг	-
	ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлээр шийдвэрлэсэн хэрэг	-
	Хэргийг хэрэгсэхгүй болгосон	1
2020 он	Шийдвэрлэсэн хэрэг	0
	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг	-
	ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлээр шийдвэрлэсэн хэрэг	-
	Хэргийг хэрэгсэхгүй болгосон	-
2021 он	Шийдвэрлэсэн хэрэг	5
	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг	3
	ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлээр шийдвэрлэсэн хэрэг	2
	Хэргийг хэрэгсэхгүй болгосон	-
2022 он	Шийдвэрлэсэн хэрэг	2
	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэрэг	2
	ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлээр шийдвэрлэсэн хэрэг	-
	Хэргийг хэрэгсэхгүй болгосон	-

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл

Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр 2017 онд тендерийн маргаантай холбоотой 2 хэрэг, 2019 онд 1, 2021 онд 5, 2022 онд 2 хэрэг тус тус шийдвэрлэгдсэн байна. Эдгээрээс хялбаршуулсан журмаар 6 хэргийг, ЗХШХШТХ-ийн 106 дугаар зүйлээр 3 хэргийг, 1 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэгдсэн байна.

- **Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн талаар:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 14.1.4, 14.1.6 дахь заалтад заасан нөхцөл үүссэнийг тогтоосон тухай энэ хуулийн 52¹.1-д заасан эрх бүхий улсын байцаагчийн шийдвэрийг үндэслэн тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтөлж, нийтэд мэдээлэхээр заасан. Мөн Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолоор “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” болон “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг баталж хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, 14.1.6, 14.1.7 дахь заалтад заасан нөхцөл үүссэн эсэхийг улсын байцаагчаар дамжуулан хяналт тавьж байна.

Худалдан авах ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгжүүдээс тендер шалгаруулалтад бүрдүүлж байгаа баримт, мэдээллийг мэдээллийн сангаас шууд авч тендерийн үнэлгээнд харгалзан үзэхийг Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-аар зохицуулсан. Энэ хүрээнд худалдан авах ажиллагааны цахим системийг хуулийн этгээдийн бүртгэл, татвар төлөгчдийн мэдээллийн сан, санхүүгийн цахим тайлангийн систем, тээврийн хэрэгсэл эзэмшигчдийн бүртгэл, дээд боловсролын гэрчилгээ эзэмшигчд бүртгэл, барилгын тусгай зөвшөөрлийн бүртгэл, нийгмийн даатгалын бүртгэлийн мэдээллийн сан, арилжааны банкны баталгааны бүртгэл, тоон гарын үсгийн бүртгэлийн систем, шүүхийн шийдвэр, шүүхийн төрөлжсөн архивын бүртгэлтэй холбож тендерийн үнэлгээнд харгалзан үздэг байна.

Ховд аймгийн хүрээнд: худалдан авах ажиллагааны ерөнхий байцаагчийн удирдамжийн дагуу захиалагч байгууллага, аж ахуйн нэгжээс ирсэн нотлох баримт дээр үндэслэн 2020 онд 12, 2021 онд 16, 2022 онд 8 аж ахуйн нэгжийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулж, нийт 36 компанийн жагсаалтыг Сангийн яам болон Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д мэдээлсэн байна. Дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 2-оос үзнэ үү.

Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан аж ахуйн нэгжүүдийн 77.8 хувь нь хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.6-д заасан илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлсэн, 16.7 хувь нь хуулийн мөн зүйлийн 14.1.4-д заасан сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, болон эрх бүхий улсын байцаагч тогтоосон, 5.5 хувь нь татвар төлөгчийн талаарх албан бичгээр нотлох баримтыг хуурамчаар ирүүлсний улмаас тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан байна.

2.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль үр ашигтай хэрэгжиж байгаа эсэх, гарч буй хүндрэл бэрхшээлийн талаар:

2021 онд Ховд аймагт хэрэгжих Орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сан, Замын сан, Хөшөөт хөгжил сан, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 118 ажил, төсөл хөтөлбөр арга хэмжээнээс аймгийн Засаг даргын дэргэдэх худалдан авах ажиллагааны албаар дамжуулан хэрэгжүүлэхээр жилийн эцсийн байдлаар 118 ажлыг цахим системд 100% зарлан худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулан гэрээ байгуулах мэдэгдэл олгосон ба худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Үүнээс:

- Нээлттэй тендер шалгаруулалтаар – 25 ажил;
- Харьцуулалтын аргаар – 74 ажил;
- Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмаар – 4;
- Шууд гэрээ – 3 ажил;
- Шууд худалдан авалтаар – 12 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Нээлттэй тендер шалгаруулалт амжилтгүй болсноос шалтгаалан шууд гэрээ байгуулах журмыг хэрэглэх тохиолдол нэлээдгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-д шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг 20.0 сая төгрөг байхаар тогтоосны дагуу 20.0 сая төгрөгөөс доош төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авалтаар авч байна.

Харин нээлттэй тендер шалгаруулалт зарлаад 2 удаа амжилтгүй болсон тохиолдолд төсөвт өртгөөс хамаарахгүйгээр шууд гэрээ байгуулан ажилладаг. Үүний дагуу 2021 онд ЗГХЭГ-аас эрх шилжиж ирсэн “Сум, багийн хөгжлийг дэмжих” 480.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг 10 багц болгон зарласан ба 2 багцад нь оролцогч ирж, шалгарсан ба бусад 8 багцад нээлттэй тендер 2 удаа зарласан тул хуулийн дагуу шууд гэрээ байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн. Мөн ЗГХЭГ-аас эрх шилжиж ирсэн “Сум багийн хөгжлийг дэмжих” 200.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг 5 багц болгон зарласан ба 3 багцад нь оролцогч ирж, шалгарсан ба бусад 2 багцад нээлттэй тендер 2 удаа зарласан тул хуулийн дагуу шууд гэрээ байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн байна.

Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний дийлэнхийг шууд гэрээ байгуулан ажиллаж хэт жижиглэн хэрэгжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр өгөөжид сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлэх талтай.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд өмнөх оноос шилжсэн 799.1 сая төгрөгийн 6 ТАХ-г өмнөх оноос 293.3 сая төгрөгийн 6 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 94 ТАХ-нд 4,143.5 сая төгрөг төлөвлөснөөс 2,860.8 сая төгрөгийн өртөг бүхий 26 ТАХ-г нээлттэй тендер шалгаруулалт, 74.0 сая төгрөгийн 2 ТАХ-г олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаагаар, 128.5 сая төгрөгийн 12 ТАХ-г харьцуулалтын аргаар, 2,687.2 сая төгрөгийн 49 ТАХ-г шууд гэрээ байгуулан хэрэгжүүлжээ. Жаргалант сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 120.7 сая төгрөгийн 6 ажил харьцуулалтын аргаар, 168.7 сая төгрөгийн 17 ажлыг шууд худалдан авалтаар хэрэгжүүлсэн байна.

2021 онд шинээр хэрэгжүүлэх 44 төсөл, арга хэмжээг 100 хувь нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж, 2 багцын 16 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар дахин зарлаад оролцогч ирээгүй тул шууд гэрээ байгуулсан байна. Мөн 2019 онд босго үнээс давсан “Эв эеийн хүч” худалдааны төвийн халаалтын ажлыг халаалтын улирал эхлэх болсонтой холбоотойгоор аймгийн Онцгой комиссын шийдвэр гарч шууд худалдан авалтын аргаар гүйцэтгэгч байгууллагыг шалгаруулсан байна. 2020 онд аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 411.0 сая төгрөгийн 5 ажил шууд гэрээ байгуулан ажиллажээ.

Сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах 20.0 сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулдаг. Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан сонгон шалгаруулалт явуулах бөгөөд тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд орон нутгийн иргэдийг өргөнөөр оролцуулах зарчмыг баримталдаг. Олон нийтийн худалдан авах ажиллагааны журмыг хэрэгжүүлэх ажил сумуудад хангалтгүй байгаа учир энэ журмыг хэрэгжүүлэн аль болох шууд худалдан авалтаас татгалзах чиглэлийг баримтлан иргэдийн бүлэг байгуулах арга зүйн сургалтын талаар цахим системээр зөвлөгөө өгч ажилласан байна.

Ховд аймгийн ТЕЗ-ийн 2021 оны худалдан авах ажиллагааны тайланд “Сумдын хувьд 464 ажлыг шууд худалдан авалтаар зохион байгуулсан нь энэ оны бүх сумдын нийт худалдан авалтын 85.4 хувийг эзэлж байна” гэж тайлагнасан байна. Нийт тендерийн 85.4 хувийг шууд худалдан авалтаар авч байгаа нь өрсөлдөөнт бус ялагч шалгаруулсан худалдан авах ажиллагааны тоо өсөх, авлигад өртөх, ил тод байх зэрэг худалдан авах ажиллагааны үндсэн гол зарчимтай зөрчилдөж байна.

Түүнчлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төлөвлөлт, төсөвлөлтийн шатны алдаа нийтлэг гаргаж байна. Тухайлбал, Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд төсөл, арга хэмжээг магадлалаар баталгаажсан зураг төсөвгүйгээр, том дүнгээр төсөвт өртгийг баталж худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас улсын төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, төсөл, арга

хэмжээ хугацаандаа ашиглалтад орохгүй удаашрах нөхцөл байдал үүсэхээр байна гэж дүгнэсэн.

Хүснэгт 14. Зураг төсөв нь хийгдээгүй 2022 онд эхлэх барилга байгууламжийн жагсаалт

	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Зураг төсөл боловсруулах ажлын даалгавар баталсан огноо
		Эхлэх	Хугацаа		
1	Сумын тохижилт (Ховд, Дуут)	2022	2022	196.00	2022.04.08
2	Түүхий эдийн төвийн барилга (Ховд, Мөст)	2022	2022	396.00	2022.04.18
3	Дотуур байрны барилга, 150 ор (Ховд, Манхан сум, Төгрөг гол баг)	2022	2023	3,135.00	2022.08.25
4	Цэцэрлэгийн барилга, 150 ор (Ховд, Жаргалант сум, Бичигт баг)	2022	2023	2,800.5	2022.10.01
5	Цэцэрлэгийн барилга, 75 ор (Ховд, Жаргалант сум, Алагтолгой баг)	2022	2023	1,909.8	2022.10.01
6	Кино театрын барилга (Ховд, Жаргалант сум)	2022	2023	2,4449.0	2022.10.01
7	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл (Ховд, Мянгад сум)	2022	2023	1,704.1	2022.05.20
НИЙТ				12,591.50	-

Энэхүү аудитын дүгнэлтэд захиалагч ТАХ-ний тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй, тендерийн баримт бичгийн шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна гэж дүгнэсэн. Тухайлбал, багшийн хөгжлийн төвийн төсөв ажлын тендерт шалгарсан компанийн дуусаагүй ажлын гүйцэтгэл 90 хувьд хүрээгүй, туслан гүйцэтгэгч компани татварын өртэй байхад хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгаруулсан байна.

Мөн бүрэн дууссан барилга, байгууламжийн гүйцэтгэлд хяналтыг хэрэгжүүлэхэд төсөвт өртөгт суугдсан зарим ажлыг дутуу гүйцэтгэсэн зөрчил дутагдал нийтлэг гарч байгааг мэргэжлийн байгууллагын хийсэн дүгнэлтээс харж болохоор байна.

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайланд “2022 онд аймгийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, их засварын ажилд батлагдсан 2,422.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 22 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 8, харьцуулалтын аргаар 3 төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулж, 11 шууд гэрээ байгуулсан байна. 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 22 төсөл, арга хэмжээнээс 18 төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж, 517.3 сая төгрөгийн санхүүжилт авсан 4 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл үр дүн хангалтгүй байна.” гэж дүгнэсэн байна.

Иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй, зарим ажил акт баримтаар баталгаажаагүй, орлого аваагүй, чанаргүй, ажлаа дутуу хийсэн, тоо хэмжээ дутсан хугацаандаа хүлээлгэн өгөөгүй, хүлээн авсан ажил нь сайжруулах шаардлагатай, урсгал зардалд зарцуулсан зөрчил түгээмэл байна. Хөтөлбөр төсөл, арга хэмжээнээс хөрөнгө оруулалтын бус шинжтэй урсгал зардлууд санхүүжүүлжээ. Тухайлбал, “Түүнчлэн 2019-2020 онуудад хөрөнгө оруулалтын шинж чанаргүй 39 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 735.5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан нь Төсвийн тухай хууль болон ОНХС-гийн журамтай нийцэхгүй байна” гэж Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн аудитын тайланд дүгнэсэн байна. Орон нутгийн хөгжлийн хөгжлийн сангийн санхүүжигдэх хөрөнгө оруулалтын ихэнх ажлууд чанарын шаардлага хангаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй, ажлын тоо хэмжээгээр нэмэгдээгүй байна.

Мөн сүүлийн жилүүдэд барилгын материалын үнэ өссөнтэй уялдаж зарим компани гэрээнээсээ татгалзахад хүрч байгаа ба төсөв хүрэлцэхгүй, оролцогч ирэхгүй, олон удаа цахим системд дахин дахин зарлаж, цаг хугацаа алдаж байгаа зэрэг нь өрсөлдөөнт бус журмыг түлхүү ашиглах нөхцөл болсон байна.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудас шинэчлэгдэж төрийн зарим байгууллагаас авах тодорхойлолтуудыг цахимаар шалгах боломж бүрдсэн нь тендерт оролцогчдын цаг хугацаа, цаас хэмнэсэн ихээхэн ач холбогдолтой болсон байна. Тухайлбал, нийгмийн даатгал, татвар, боловсролын баримт бичиг, санхүүгийн чадамж, борлуулалтын орлого, авто тээврийн хэрэгслийн лавлагаа, тусгай зөвшөөрөл гэх мэт нэлээн хэдэн шалгуур үзүүлэлтийг цахим системээс үзэх боломжтой болсон байна.

ГУРАВ.ТАЙЛАНГИЙН ҮР ДҮН, ЗӨВЛӨМЖ

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогтоос 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн УИХ-03/2325 дугаар албан бичгээр Ховд аймгийн хүрээнд худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байдал бүрэн хангагдаж байгаа эсэх, тендер шалгаруулалтад оролцож буй этгээдүүд хуулийн хүрээнд шалгарч байгаа эсэх болон 2016 оноос хойш Ховд аймагт улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл, гүйцэтгэл, мөн үнэлгээний хорооны шийдвэртэй холбогдуулан гаргасан гомдол шийдвэрлэлтийн талаар үнэлгээ хийх хүсэлтийг ирүүлсний дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ зөвхөн Ховд аймгийн хүрээнд мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийж, дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

1. Авлигын эрсдэлийн индексийн үнэлгээгээр улсын хэмжээнд байгууллагын ил тод байдал, ажилчдын хариуцлагатай байдал нь Ховд аймгийн хувьд дунджаас доогуур буюу 64.6 оноотой байгаад анхаарч ажиллах шаардлагатай илэрхийлж байна.
2. Төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудас шинэчлэгдэж төрийн зарим байгууллагаас авах тодорхойлолтуудыг цахимаар шалгах боломж бүрдсэн нь Ховд аймгийн хувьд тендерт оролцогчдын цаг хугацааг хэмнэсэн төдийгүй 2022 онд Засаг даргын Тамгын газрын А/03 дугаар тушаалаар “Үнэлгээний хорооны үйл ажиллагааг нээлттэй, ид тод зохион байгуулах журам”-ыг баталж, тендер нээсний дараа 1-3 өдөрт багтаан үнэлэх, үнэлгээний хорооны хурлыг нээлттэй, ил тод байдлыг хангах зорилгоор хурлын явцыг ил тодоор шууд иргэдэд хүргэх боломжийг бүрдүүлсэн байна.
3. Үнэлгээ хийх явцад Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019.03.11-ний өдрөөс 2019.04.17-ны өдөр буюу нэг сарын хугацаанд Үнэлгээний хороо байгуулсан нийт 23 тушаалыг¹⁵ түүвэрлэн авч хяналт шинжилгээ хийхэд нэг иргэнийг олон үнэлгээний хороонд ажиллуулж байгаа нь худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байх шаардлагыг хангахгүй, тухайн орон нутгийн хувьд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн иргэн болон төрийн бус байгууллагын төлөөлөл бүрэн хамрагдаж чадахгүй байна.
4. Үнэлгээний ажлын хүрээнд мэдээлэл цуглуулах явцад Ховд аймгийн улсын төсвийн хөрөнгөөр 2016-2022 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, түүний үр дүнг тооцсон нэгдсэн тайлан мэдээ байхгүй, мэдээ мэдээллийг олон удаа дутуу гаргаж, иж бүрэн ирүүлээгүй, ирүүлсэн мэдээлэл зөрүүтэй, төсөвт өртгийн мөнгөн

¹⁵ Ховд аймгийн Засаг даргын 2023.05.24-ний өдрийн 1/900 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэл

дүнг харилцан адилгүйгээр илэрхийлсэн зэргээс шалтгаалан үнэлгээний ажилд хүндрэл учруулж байлаа.

5. Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан”-д дурдсанаар ТЕЗ-аас хүргүүлсэн төсвийн саналд тусгаагүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын жагсаалтад тусган баталдаг талаар дүгнэлт гарсанг цаашид анхаарах шаардлагатай байна.

Тухайлбал, 2021 онд ТЕЗ-ийн саналын жагсаалтад ороогүй 24 төсөл, арга хэмжээ, 2022 онд 19 төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулж баталсан байна. Энэ нь ТЕЗ-аас хүргүүлсэн саналыг харгалзалгүйгээр төлөвлөж, улмаар санхүүжүүлж байгаа нь тухайн орон нутгийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлаагүй, төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ батлагдаж байгаагаас гадна орон нутгийн хөрөнгө оруулалтын бодлого алдагдахад хүрэх эрсдэлтэй байна.

6. Зарим төсөл, арга хэмжээг магадлалаар баталгаажсан зураг төсөвгүйгээр тойм болон ерөнхий дүнгээр төсөвт өртгийг баталж, худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас шалтгаалан улсын төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, төсөл арга хэмжээ хугацаандаа ашиглалтад орохгүй удаашрах, улсын төсвөөс үр ашиггүй зардал гарах, төсөвт тусгагдаагүй нэмэлт ажлыг бий болгох эрсдэлтэй байгааг сүүлийн 2 жилийн аудитын тайлангаар анхааруулж, холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Тухайлбал, 2022 онд эхлэх зураг төсөв хийгдээгүй барилга байгууламжийн жагсаалтад орсон Жаргалант сумын Бичигт багт хийгдэж буй 150 ортой цэцэрлэгийн барилгад 419.7 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.2 дахь заалтад нийцэхгүй байгаа талаар аудитын дүгнэлт гарчээ.

7. 2022 онд ашиглалтад орох 23 төсөл, арга хэмжээнээс 4,012.2 сая төгрөгийн 10 барилга, байгууламж ашиглалтад орж, 4,681.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 10 төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөн хугацаандаа ашиглалтад ороогүй байна.

Төсөвт өртөг нь хүрэлцээгүйн улмаас ажил нь зогссон 1 спорт заалны барилга, хугацаандаа ашиглалтад ороогүй гэрээний хугацаа сунгасан 10 төсөл, арга хэмжээ байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй сумын төвийн инженерийн нэгдсэн шугам сүлжээ, цэвэр, бохир ус болон дулаан, дулааны эх үүсвэр, Үенч сумын төвийн тохижилт, Булган -Үенч-Ховд чиглэлийн автозамын барилга, Жаргалант сумын 9, 10 дугаар цэцэрлэг, гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний ажлууд иргэдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан төсөл, арга хэмжээ болсон хэдий ч зарим сумын төвийн тохижилт, шинэ хөдөө төслүүд зэрэг нь орон нутагт хөрсөн дээрээ багц болж олон хуваагддаг, гүйцэтгэл нь хангалтгүй, үр дүн багатай, хэрэгцээ шаардлага, хүчин чадлыг үнэлэх боломжгүй байгааг аудитын тайланд дурдсан байна.

8. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өмнөх оны аудитаар өгөгдсөн 12 төсөл арга хэмжээний 1,218.5 сая төгрөгийн албан шаардлага, 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитаар 4,951.9 сая төгрөгийн 10 зөрчил илэрсэн нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийгдэж байгаа хяналт хангалтгүй байгааг харуулж байгаагаас гадна ТЕЗ-дад аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт хангагдахгүй байна.

9. Ховд аймагт 2018-2022 онд зохион байгуулагдсан тендер шалгаруулалттай холбоотой Сангийн яаманд ирүүлсэн нийт гомдлын 41.2-66.7 хувь нь үндэслэлтэй

байна гэсэн шийдвэрийг гаргасан байна. Өөрөөр хэлбэл, 2020 онд нийт гомдлын 64.3 хувь, 2021 онд 62.5 хувь, 2022 онд 66.7 хувь нь үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн байна. Энэ нь үнэлгээний хорооны гишүүд тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ зохих хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаагүй, нөгөө талаас Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2-т заасан захиалагч үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт хуульд нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна.

10. Гүйцэтгэгч аж ахуйн нэгж нь мэргэжлийн хүний нөөц дутмаг, орон нутгаас мэргэжлийн бус хүн ажиллуулдаг, инженер техникийн ажилтан байхгүй, 1 компани зэрэг олон тендер авдаг, дуусаагүй ажил ихтэй тул ажил удааширдаг, техник тоног төхөөрөмж хангалтгүй, ажлаа хугацаа хоцорч эхэлдэг зэргээс ажил гүйцэтгэх гэрээ хугацаандаа хэрэгжихгүй байна.
11. Мөн төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нь барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийг аймгийн Засаг даргад ирүүлснийг үндэслэн төсөл, арга хэмжээг хүлээн авах ажлын хэсэг, улсын комиссын бүрэлдэхүүнийг томилж байна. Комисс нь холбогдох хууль, дүрмийн дагуу зохиогчийн болон техникийн хяналтын нэгдсэн дүгнэлтүүд гараагүй байхад ТАХ-г г хүлээн авах, үүрэг даалгаврын биелэлтээр өгөгдсөн ажлууд хэрэгжээгүй байхад эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр санхүүжилтийг бүрэн олгох зэрэг зөрчил аудитын дүгнэлтээр гарсан байгааг цаашид анхаарах шаардлагатай байна.

---oOo---

Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2016-2022 онд Ховд аймагт хэрэгжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны мэдээлэл, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	ТАХ төлөв	Захиалагч	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг /сая.төг/	Гэрээний дүн /сая.төг/	Гүйцэтгэгчийн нэр
2016 он								
1	Цагдаагийн хэлтсийн барилгын их засвар /Ховд, Булган сум/		Хууль зүйн яам	2016	2016	300.0	-	-
2017 он								
	-	-	-	-	-	-	-	-
2018 он								
1	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Мянгад сум/	Гэрээ байгуулсан	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	2018	2019	1,400.0	1,057.0	ГЦЦЭ ХХК
2	Соёлын төвийн барилга, 300 суудал /Ховд, Дуут сум/	Гэрээ байгуулсан	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	2018	2019	1,300.0	1,101.4	Чандмань-Уушир ХХК
3	Спорт цогцолборын барилга, 450 суудал /Ховд, Булган сум/	Гэрээ байгуулсан	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	2018	2019	3,500.0	3,218.0	Тэнгэрийн тэмдэг ХХК
4	Хүүхдийн эмнэлгийн барилга, 50 ор /Ховд, Жаргалант сум/	Гэрээ байгуулсан	Эрүүл мэндийн яам	2018	2020	5,019.70	4,450.0	Мотоблок ХХК
5	Эрүүл мэндийн төвийн барилга /Ховд, Чандмань сум/	Гэрээ байгуулсан	Эрүүл мэндийн яам	2018	2019	980.0	958.8	Тэгшстандарт ХХК
6	Прокурорын газрын барилга /Ховд, Жаргалант сум/	Гэрээ байгуулсан	Улсын ерөнхий прокурор	2018	2019	1,400.0	1,214.6	ЭСБА интернэшнл ХХК
2019 он								
1	Сургуулийн спорт заалны барилга /Ховд, Булган сум, 1 дүгээр сургууль/	Гэрээ байгуулсан	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	2019	2020	1,100.0	989.53	Хатантүнгэл ХХК
2	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Ховд, Манхан сум/	Гэрээ байгуулсан	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	2019	2019	1,200.0	1,069.90	ГЦЦЭ ХХК
3	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, /Ховд, Дарви сум/	Гэрээ байгуулсан	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	2019	2019	1,300.0	1,078.90	Буянтын боргио ХХК
4	Спорт заалын барилга /Ховд, Мянгад сум/	Гэрээ байгуулсан	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам	2019	2020	1,000.0	773.4	Жаргалантлуу ХХК
5	Бодонч, Ангиртын голын төмөр бетон гүүр, 40 у/м /Ховд, Алтай сум/	Гэрээ байгуулсан	Зам, тээврийн хөгжлийн яам	2019	2019	1,200.0	1,125.8	ТОЁО ХХК
6	Аймгийн төвийн авто зам, гэрэлтүүлэг /Ховд, Жаргалант сум, Наран баг/	Гэрээ байгуулсан	Зам, тээврийн хөгжлийн яам	2019	2020	2,100.0	2,039.5	Түмдэлгэрэх ХХК

2020 он								
1	Спорт заалын барилга, 30*15 харьцаатай, хөл бөмбөгийн талбай /Ховд, Эрдэнэбүрэн сум/	Гэрээ байгуулсан	Боловсрол, шинжлэх ухааны яам	2020	2021	1,100.0	989.3	Буянтын боргио ХХК
2	Цэцэрлэгийн барилгын их засвар /Ховд, Булган сум/	Гэрээ байгуулсан	Боловсрол, шинжлэх ухааны яам	2020	2021	500.0	480.0	Динатос ХХК
3	Багуудыг сумын төвд холбох цахилгаан дамжуулах агаарын шугам /Ховд, Булган сум/	Амжилтгүй болсон	Эрчим хүчний яам	2020	2021	200.0	-	-
4	Баянбулаг хүүхдийн зусланг өндөр хүчдэлийн ЦДАШ-тай холбох /Ховд, Жаргалант сум/	Гэрээ байгуулсан	Эрчим хүчний яам	2020	2021	890.0	796.1	Номин-Ендэрт ХХК
5	Сумын эрүүл мэндийн төвийн барилга /Ховд, Алтай сум/	Гэрээ байгуулсан	Эрүүл мэндийн яам	2020	2021	694.10	522.8	Вивазоне ХХК
6	Эрүүл мэндийн төвийн барилга 10 ор /Ховд, Дөргөн/	Гэрээ байгуулсан	Эрүүл мэндийн яам	2020	2021	1,500.0	1,329.1	Толхын ойл ХХК
2021 он								
1	Үүрэн холбооны сүлжээ /Ховд/	Гэрээ байгуулсан	Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга	2021	2021	300.0	287.7	Монкабель системс ХХК
2	“Бадамлах дөл” дулааны станцын өргөтгөл /Ховд, Жаргалант сум, Наран баг/	Амжилтгүй болсон	Эрчим хүчний яам	2021	2021	1,000.0	-	-
2022 он								
1	Сургуулийн барилга 160 суудал /Ховд, Мөнххайрхан сум/	Гэрээ байгуулсан	Боловсрол, шинжлэх ухааны яам	2022	2023	4,900.0	4,617.7	Вивазоне ХХК
2	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор, /Ховд, Дуут сум/	Гэрээ байгуулсан	Боловсрол, шинжлэх ухааны яам	2022	2023	2,600.0	2,355.7	Хатантүнгэл ХХК
3	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Ховд, Булган сум, Баянсудал баг/	Гэрээ байгуулсан	Боловсрол, шинжлэх ухааны яам	2022	2023	4,168.60	3,789.9	Толхын ойл ХХК
4	Сумын төвийн хатуу хучилттай авто зам, /Ховд, Алтай сум/	Гэрээ байгуулсан	Зам, тээврийн хөгжлийн яам	2022	2023	1,100.0	1,050.5	Өсөн дэмжих зам ХХК
5	Халаалтын зуухын өргөтгөл /Ховд, Зэрэг сум/	Гэрээ байгуулсан	Эрчим хүчний яам	2022	2023	600.0	599.1	МЭЗ ХХК
6	Бизнес инкубатор төвийн барилга /Ховд, Булган сум/	Гэрээ байгуулсан	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2022	2023	4,800.0	4,592.5	Харганы ус констракшн ХХК

7	Үүрэн сүлжээний антен /Ховд/	Гэрээ байгуулсан	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	2022	2022	400.0	394.3	Мянган өндөр цахир ХХК
---	------------------------------	------------------	-------------------------------------	------	------	-------	-------	------------------------

Эх сурвалж: Төрийн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн мэдээлэл

Ховд аймагт 2016-2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн төсөл, арга хэмжээний мэдээлэл, барилга байгууламжийг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл

